



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.06.12, ЛХАГВА ~ №111 (1163)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Иргэдийн төлөх телевизийн хураамжийг нэмэхийг зөвшөөрөхгүй Хуулиар төлбөр нэмдэг байдал даамжирвал иргэд хохирно гэв. > 2	Нэг давхруудад “төвхнөсөн” нийтийн хоолны газруудад зовлон их Орон сууцны дор үйл ажиллагаа явуулдаг 680 орчим хоолны газар бий. > 4	Хятадын импорт буурч байгаа нь бидэнд болгоомжлох дохио өгч байна Манай гол асуудал бол инфляц биш гадаад худалдаан дээр гарч болох өөрчлөлт. > 11	ZGM DAILY	FULL ENGLISH PAGE INSIDE > 7
--	---	---	------------------	--

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Бүгд Найрамдах Кыргыз улсад хийх Ерөнхийлөгч Х.Баттулгын айлчлал өнөөдөр эхэлнэ. **2018 оны төсвийн гүйцэтгэлд** хийсэн аудитын дүгнэлтийг Г.Занданшатарт өргөн барилаа. **ХЗДХ-ийн сайд Ц.Нямдоржийг** огцрохыг шаардсан жагсаал хоёр дахь өдрөө үргэлжлэв. **УИХ-ын гишүүн** С.Бямбацогтыг ТББХ-ны даргад томилохыг дэмжлээ.

ЭДИЙН ЗАСАГ

Уул уурхай дахь гадаадын хөрөнгө оруулалт 16 хувиар буурч, 443 сая ам.долларт хүрчээ. **БНХАУ-ын нүүрсний импорт** өнгөрсөн сард 23 хувиар өссөн байна. **Монгол Улс нарны эрчим** хүчний нэгжийн үнийн дээд хязгаарыг 12 центээр тогтоолоо. **Топ 20 индекс 0.09 хувиар** буурч, 19,688.16 нэгжид хүрсэн байна.



НИЙГЭМ

Монголд амьдардаг казахстан иргэдийн 93 хувь нь Ерөнхийлөгчийнхөө сонгуульд санал өгчээ. **Шинэ хот “Аэросити”-ийн** хилийн цэсийг 25,282 га талбайгаар тогтоох санал танилцуулав. **Галт тэрэгний үйлчлэгч 23 кг** дэрвэгэр жиргэрүүг хууль бусаар хил нэвтрүүлэх гэж байжээ. **Өнөөдрийн дотор татвараа** төлсөн жолоочид хариуцлага тооцохгүй.

ДЭЛХИЙ

Amazon компани дэлхийн хамгийн шилдэг брэндээр шалгарлаа. **Туркийн нисгэгчдийг F-35-ын** сургуульд оролцуулахыг АНУ зогсоов. **Египет улс Тутанхамоны цээж** баримлыг буцааж өгөхийг Их Британиас шаардав. **Канад 2021 оноос нэг удаа**-гийн хэрэглээний хуванцрыг хориглоно.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2018.06.12

22° | 11°
ҮҮЛ БАГАСНА

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ
8 ДУГААР НҮҮРЭС УНШИНА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ЯДУУ БУУРАЙ УЛСУУДЫН ДИПЛОМАТ АЛБЫГ ХАР ТАМХИНЫ БҮЛЭГ “ОЛЗОЛДОГ”



Дипломат протоколд заасныг ёсчлон мөрдөж, гадаад ертөнцөд “нэг амаар” ярьж чаддаг мэргэшсэн дипломатчдын сайн туршлага олон нийтэд бүү хэл ГХЯ-нд мартагдсан гэлтэй. ► 3

ЗГМ: ЗОЧИН

Бид утааг 70-80 хувь бууруулах шинэ технологийг боловсруулсан

Б.Бадамцэцэг
ЗГМ

Эрдэм шинжилгээ туршилтын “МонХимо” төвийн захирал Д.Дэмбэрэлнямбатай ярилцлаа. Түүнийг монголчууд ясны сийрэгжилтээс сэргийлэх болон үе мөчийг нөхөн төлжүүлэх үйлчилгээтэй “Адууны яснаас гаргаж авсан кальцийн бэлдмэл” бүтээлүүдээр нь мэднэ. Харин энэ удаад Улаанбаатар хот болон бусад суурин газрын утааг 70-80 хувь бууруулах шинэ технологи боловсруулсан талаар нь онцлон ярилцав.

дэлхий

Цэцэглэж буй шүлтлэг усны наймаа

Лесли Паттон

Хүн төрөлхтний хэрэглээнд олон зуун жилийн түүхтэй шүлтлэг усыг анагаах эрдэмтэй рашаан, амьдралыг залуужуулагч оргилуун булагтай холбон ойлгох нь түгээмэл. Өдгөө ч хүчиллэг усыг цангаа тайлах төдий бус, бодисын солилцооны тэнцвэрийг хангах, эрүүл энх амьдрах, урт наslaх нууцын эцэс төгсгөлгүй эх сурвалж хэмээн үзсээр байна. Дэлхийн тэргүүлэх компаниуд шүлтлэг усны үйлдвэрлэлд хошуурч буйн шалтгаан ердөө энэ. АНУ-д 17 тэрбум ам.доллараар хэмжигдэж буй лонхонд савласан шүлтлэг

усны үйлдвэрлэл хурдацтай нэмэгдсээр. “Бүгд эрүүл мэнддээ анхаардаг болсон цагт энгийн ус хэрэгцээ хангахаа болилоо” хэмээн Bloomberg Intelligence-ийн Кен Ши тайлбарлав.

Шүлтлэг усны хэрэглээ олон арван жилийн түүхтэй. Гэхдээ ердөө сүүлийн хэдхэн жилийн дотор шүлтлэг ус зах зээлд жинхэнэ тэсрэлт үүсгэж нэр хүндтэй оддын сонголт, сошиал мэдээллийн хэрэгсэл, эрүүл мэндийн сүүлийн үеийн чиг хандлагыг тодорхойлогч болж хувирлаа.

► 9

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭДИЙН ЗАСАГ

Гоо сайхны төлөөх халуурал энгийн рүү шилжинэ

Г.Байгал
@baigalZGM

Гоо сайхны ертөнцөөр дураараа аялж, шинэ бүхнийг нь туршиж, хэрэглэх хүсэлтэй бүхэл бүтэн үе бий болсноор дэлхийн косметик үйлдвэрлэл үлэмж хэмжээгээр өсөөд байна. Орчин үед охид бүсгүйчүүд хэзээ хэзээнээс илүү гоо сайханд анхаарах болж, гадаад үзэмжээрээ гайхуулахын тулд хэд бол хэдийг үрэхэд бэлэн болжээ. Энэ оргилсон хүслийг нь Instagram, Facebook зэрэг нийгмийн сүлжээн дэх олны танил одод, сошиал нөлөөлөгчид улам өдөөж, худалдан авалтаа тэвчих амаргүй болгож байна.

Гал дээр тос нэмсэн, нийгмийн сүлжээн дэх сошиал нөлөөлөгчид гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчидтэй нягт хамтран ажиллаж, бараг өдөр бүр шинэ бараа сурталчилж, санал сэтгэгдлээ хуваалцдаг. Энэ нь ч утаснаасаа салахаа больсон орчин үеийн хэрэглэгчдийг урхидах хөнгөхөн өгөөш болж, гоо сайхны бүтээгдэхүүний хэрэглээ, худалдан авалт ердийнхөөс хэд дахин нэмэгдэхэд хүргээд байгаа аж. Энэ хандлага манайд ч тод харагдах болсон гэдэгтэй уншигч та ч санал нэгдэх биз.

► 12

АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1322.75 0.38%	5874 1.29%	98.700 0.13%	110.70 0.12%	99.330 0.12%	2,642.76	390.35	40.53

Улс төр

БАЙНГЫН ХОРОО

Иргэдийн төлөх телевизийн хураамжийг нэмэхийг зөвшөөрөхгүй

Хуулиар төлбөр нэмдэг байдал даамжирвал иргэд хохирно гэв

Б.Гарьд
ЗГМ

Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар Засгийн газраас санаачилсан Өргөн нэвтрүүлгийн хуулийн төслийг парламентаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэв. Засгийн газар техник, технологи хурдацтай хөгжиж олон телевиз, радио өргөн нэвтрүүлгийн цагтай болсон, түүнийг нь хэрэглэгчид зурагт, радиогоор хүлээн аваад зогсохгүй гар утас, компьютер, машины дэлгэцээр үздэг болсонтой холбогдуулан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг санаачилж, зохицуулалт хийх шаардлагатай болсон гэж үзжээ. 2005 онд Олон нийтийн радио телевизийн тухай хуулийг баталсан боловч тус хууль зөвхөн МҮОНРТ-ийн нэвтрүүлгийн бодлогыг тодорхойлсон. Тиймээс бусад телевизийн өргөн нэвтрүүлгийн бодлого алдагдсан. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан монгол контент үйлдвэрлэл, оюуны өмчийг үнэлнэ гэсэн заалт хэрэгжих боломжтой болно гэж төсөл санаачлагч тайлбарлав.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 84 телевиз байгаа. Үүний 39 нь нийслэлд, үлдсэн нь орон нутагт үйл ажиллагаа



С.Батсайхан / ЗГМ©

явуулж буй аж. Мөн кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгч Улаанбаатарт 77, орон нутагт найм, Олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч 16 байгаа юм. Тиймээс эдгээр телевизийн үйл ажиллагааг зохицуулах үүднээс тус хуулийн төслийг парламентаас яаралтай батлах шаардлагатай гэж ЗГХЭГ-аас төслийг өргөн барьснаа тайлбарлав. Мөн төсөл санаачлагчид телевизийн өргөн нэвтрүүлгийг зохицуулах хууль байхгүйгээс эфирийн цагаа дүүргэхийн тулд солонгосын сериал, хүүхдэд хориотой бүтээлүүдийг хяналтгүй гаргаж байгаа гэсэн юм.

Харин гишүүд контент үйлдвэрлэгч телевизээс яаж мөнгөө авах нь ойлгомжгүй байна, олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч телевизүүдэд мөнгө өгдөг болсноор иргэдийн төлбөр төлөх хэмжээ нэмэгдэнэ

гэсэн шүүмжлэлтэй хандаж байна. УИХ-ын гишүүн Н.Энхболд “Хуулийн төслийг өргөн барьж байх үед контент үйлдвэрлэгчид дамжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа Юнивишн, Скаймедиа зэргээс мөнгө авахаар тусгасан байсан нь маргаан тарьсан.

Контент чанаржиж, телевизүүд рекламаас өөр төрлийн орлоготой болно

Тиймээс хэрэглэгчээс авах төлбөрийн 20 хувийг телевизүүдэд өгье гэдэг дээр тогтсон” гэв. Харин үүнийг эсэргүүцэж

О.Баасанхүү гишүүн “Намайг Өргөдлийн байнгын хорооны даргаар ажиллаж байхад иргэд телевизийн төлбөр болох 1650 төгрөгийг тэглэж өгөөч гэсэн өргөдөл хүсэлтийг ихээр ирүүлдэг байсан. Гэтэл одоо бүр 20 мянган төгрөгөөр нэмэх гэж байгаа нь буруу. Та нар баян байж болно. Иргэдэд чинь 20 мянган төгрөг бол их мөнгө шүү. Та нарын сурталчилгааг үзэхийн тулд иргэд мөнгө нэмж төлнө гэж байхгүй. Тэгж л их мөнгө нэмэх хүсэлтэй байгаа юм бол төсөвтөө суулгаад, контент үйлдвэрлэгчдэд мөнгө олго” гэсэн юм.

УИХ-ын гишүүн Я.Содбаатар “Телевизийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгохдоо шалгуурыг өндөр тавьж, босгыг нэмэхгүй бол хоёрхон камертай студи хэлбэрийн компани үндэсний хэмжээнд нэвтрүүлэг цацдаг телевиз гээд гүйгээд байна. Тиймээс техник,

ажиллах хүчин зэрэг боломжийг нь харгалзан зөвшөөрөл олгох шаардлагатай” гэв.

Мөн гишүүд бүх телевиз орон нутагт гардаг байх боломжийг нэмэгдүүлэх, дамжуулах үйлчилгээ эрхлэгчид телевизийн нэвтрүүлгийг ухрааж, нөхөж үзсэнээс орсон төлбөрийг дангаараа ашигладгийг болиулах ёстой гэж үзэж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийг хэлэлцэхийг парламент зөвшөөрвөл энэ мэт олон талаас нь ярих, олон талын эрх ашгийг тусгах болсон учраас байнгын хорооны гишүүд тусдаа Ажлын хэсэг байгуулахаар тохиров. Тус ажлын хэсгийг хаврын чуулганы үлдсэн хугацаанд энэ хууль дээр онцгой анхаарч зуны турш сайн судлаад байр сууриа нэгтгэн намрын чуулганы эхэнд батлах ёстой гэж байнгын хорооны дарга даалгав. [ЗГМ]

БАЙР СУУРЬ



Б.ПҮРЭВДОРЖ:Ч.УЛААН САЙДЫГ АТГ-ААР ШАЛГУУЛНА

Засгийн газраас нийт таван сая амьд малыг экспортлох зөвшөөрлийг олгохоор болж байна. Тухайлбал, зөвхөн нэг компанид давуу эрхтэйгээр олгож байгаа нь бидний гайхширлыг төрүүлээ. Амьд малыг экспортод гаргахад хоёроос гурван жилийн дараа дотоодын үйлдвэр хаагдахад нэг компани үнэ тулгаж, малыг хямд үнээр авах нөхцөл байдал руу шилжинэ. ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан энэ сарын эхээр БНХАУ-д айлчилж малын экспортын талаар ярилцсан. Мөн энэ асуудлаар Мэргэжлийн хяналтын газрын дарга ярилцсан байна лээ. Тэд Монголын махны экспортыг устгахын төлөө явж байна. Иймээс Монголын махны холбоо болон мэргэжлийн холбоод үүнийг эсэргүүцэж байгаа. Бидний зүгээс нэг компанид давуу эрх олгосны цаана албан тушаалтны тодорхой хэмжээний хувийн эрх ашиг байгаа хэмээн үзэж буй. Тэгэхээр хоёр албан тушаалтныг АТГ-д

шалгуулах хүсэлтийг өгнө. Манай холбооноос Ерөнхий сайд У.Хүрэлсүх, ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан нарт дээрх асуудалтай холбоотой албан бичгийг энэ оны дөрөвдүгээр сарын эхээр явуулсан боловч одоог хүртэл хариу өгөөгүй. Малыг амьдаар гаргах асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, махны экспортдог ноцтой хохирол учруулж буй энэ асуудалд яаралтай шийдвэр гаргах тухай албан бичгийг хүргүүлж байна. Амьд мал гаргахын цаана БНХАУ өөрсдийнхөө иргэдийг малжуулах хөтөлбөр явагдаж байгаа.

Мөн манай ноолуур БНХАУ-ын ноолуураас илүү чанартай. Энэ үед БНХАУ-ын ноолуурын чанар унаж эхэлж буй. Яг энэ үед манайхаас ямаа авснаар ноолуурын салбарт ноцтой хохирол учруулах эрсдэлтэй. Тиймээс бид бүхэн амьд малын экспортыг зогсооно гэж найдаж байна.

Ч.УЛААН:ХУУЛИЙН ШААРДЛАГА ХАНГАЖ БАЙГАА БОЛ ХЭНИЙ ДҮҮ БАЙХ НЬ ХАМААГҮЙ

шүүмжилж байсан юм.

Ч.Улаан:

-Би БНХАУ-д айлчлахдаа мал амьдаар нь гаргах тухай асуудлыг огт яриагүй. Үүнийг би удаа дараа хариуцлагатайгаар мэдэгдэж байгаа. Өмнөд хөршид хийсэн айлчлалаар мах, махан болон сүү сүүн бүтээгдэхүүн, гурил, буудай, хөх тариа экспортлох боломжийг бүрдүүлэх зорилготой явсан. Гааль, Мэргэжлийн хяналтын байгууллагын үнэлгээ шинжилгээ, харилцан протокол тохирох ажлыг хийсэн. Засгийн газрын 18 дугаар тогтоолоор малыг амьдаар нь гаргаж болох тухай заасан байгаа. Тэгэхдээ үржлийн бус эр хонь, ямааны байж болох нөөцийн 20 хүртэл хувийг экспортлох чиглэлийг аймгийн удирдлагуудад өгсөн. Тиймээс мал амьдаар нь гаргах

ажлыг орон нутаг зохион байгуулна. Харин манай яаманд бодлогоор дэмжлэг үзүүлэх үүрэг өгсөн. Тэр нь аймгуудад хэдэн мал гаргахыг тогтоож өгөх хэмжээнд хязгаарлагдана. Мөн эрүүл бүсийг тогтоох үүрэг бий.

Мал экспортлох ажлыг яамны түвшинд ярьж эхлээгүй байна. Мэргэжлийн хяналт, гаалийн байгууллага харилцан нөхцөлөө тохирох ажил хийж байгаа. Үүний дараа хоёр улсын яам хоорондын гэрээг хийнэ. Б.Пүрэвдорж нарын яриад байгаа дүүгийнхээ компанид эрх олгосон гэдэгт хариулахад хэний дүү байх нь хамаагүй. Гагцхүү Засгийн газрын тогтоолыг биелүүлж ажиллана. Шаардлага хангасан компанид эрх олгоно. Хууль, дүрмийн дагуу шаардлага хангасан компанид эрх олгож ажиллана. [ЗГМ]

Зөвлөх үйлчилгээний дэлгэрэнгүй болон хураангуй жагсаалтыг бүрдүүлэх санамж

Энэхүү зарлалыг зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалт бэлтгэх зорилгоор өдөр тутмын сонин хэвлэл болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд нийтэлнэ. Захиалагч тухайн зарын дагуу саналаа ирүүлсэн зөвлөх болон хуулийн 36.5 зүйлд заасан бусад этгээдийн нэрсээс бүрдсэн дэлгэрэнгүй жагсаалтыг гаргана.

Дэлгэрэнгүй жагсаалтад хамрагдсан зөвлөхүүдээс хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлага болон захиалагчаас тогтоосон чадавхын үзүүлэлтийг хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг захиалагч сонгож, хураангуй жагсаалт гаргана.

Хураангуй жагсаалтад орсон зөвлөхөд бэлтгэсэн тендерийн баримт бичгийг ажлын даалгаврын хамт хүргүүлнэ.

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ нь Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх тул зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, яамны стратеги, зорилтуудыг хэрэгжүүлэх явцад малчид, иргэдээс өгсөн үнэлэлт, дүгнэлтийг судалж судалгаанд үндэслэн цаашид боловсруулах бодлогын баримт бичгийг сайжруулах арга замыг тодорхойлон үйл ажиллагаандаа тусгаж, үр дүнд хүрэхэд чиглэгдэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн ерөнхий танилцуулга;
- Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар;
- Судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлын чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан ажлын туршлагатай;
- Судалгаа, шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019.06.18-ны 12 цаг 00 минутын хооронд авч болно. Тендерийг цахиммиар зохион байгуулж байгаа учир 2019.06.20-ны өдрийн 12 цаг 00 минутын дотор WWW.TENDER.GOV.MN сайтаар ирүүлнэ үү.

ГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ 16А, ЗАСГИЙН ГАЗРЫН 9 ДҮГЭЭР БАЙР, А КОРПУС, ХХААХҮЯ-НЫ 404 ТООТ ӨРӨӨ. УТАС: 261691

ЗАСГИЙН ГАЗАР

Энэтхэгийн Элчин сайд газрын тосны үйлдвэр барих ажлыг “шалгав”

Жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулж 1.2 тэрбум ам.долларын импортыг орлох, стратегийн ач холбогдолтой үйлдвэр барих ажил үргэлжилж байна. Засгийн газраас тус үйлдвэрийн төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах шугамын ажилд орон нутгийн иргэдийг оролцуулж, аж ахуйн нэгжүүд бетон зуурмаг, цемент, хайрга, бусад материал, ажилчдын хоол хүнс, бараа зэргийг нийлүүлж байгаа юм. Харин БНЭУ-ыг манай улсад төлөөлөн суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мохиндер Пратап Сингх газрын тосны үйлдвэрийн ажилтай танилцжээ. Тэрбээр үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил, дэд бүтэц, шугам сүлжээний ажилтай танилцаад “Богино хугацаанд ийм их ажил амжуулсныг нүдээр хараагүй бол итгэхгүй байлаа. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл товлосон цаг хугацаандаа амжилттай хэрэгжинэ гэдэгт бүрэн итгэл төрлөө” хэмээсэн.

Төмөр замын ажлыг өнгөрсөн сард дуусгасан бол автозамын ажил 80 орчим хувьд хүрчээ. Алтанширээ сумыг аймгийн төвтэй 16.36 км автозамын бүтээн байгуулалтад зэвсэгт хүчний ангиуд гүйцэтгэгчээр ажиллаж байгаа аж. Мөн төмөр зам, автозумаас гадна цахилгаан хангамжийн 110 КВ-ын дамжуулах агаарын шугам, дэд станцыг долдугаар сарын 1-н гэхэд хүлээлгэж өгөхөөр төлөвлөсөн байна. Харин үйлдвэрийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг наймдугаар сараас эхлүүлэхээр Засгийн газраас шийдвэрлэжээ. [ЗГМ]

Нийтлэлчийн булан



С.Батсайхан / ЗГМ©

Ядуу буурай улсуудын дипломат албыг хар тамхины бүлэг “олзолдог”

ГХ-ны сайдын ачаар хар тамхины хэргүүд илэрч байгаа мэтээр “далийж” эхлэв

Э.Батцэцэг
ЗГМ

Дипломатууд хар тамхины хэрэгт холбогдсон дуулиан гол асуудлаасаа хазайж, улс төрийн өнцөг рүү орчихлоо. Монголын төр хар тамхи түгээн дэлгэрүүлэхэд гар бие оролцож байгаагаас өөрцгүй ойлголт төрүүлсэн энэ хэрэг анхны тохиолдол биш байсан нь харамсалтай. Хууль бус тамхины наймааны 20 гаруй хэрэг гарч, тэр

тоолонд Монгол Улсын нэр төр шаварт хутгалдсаар байв. Гэвч тухай бүрт нь ГХЯ-аас хариуцлага тооцох, дахин гаргуулахгүй байх арга хэмжээ авахын оронд нуун дарагдуулсаар ирсэн нь өнөөдрийн 70 кг героин хүртлээ өндрөө авах нэг шалтгаан болсон. Гэхдээ энэ удаад монголчууд улсаа төлөөлж яваа дипломатуудаа гэмт хэрэгт холбогдсоныг Германы хэвлэлээс мэдэж авлаа. Хариуд нь ГХ-ны сайд мэдээлэл хийж, УИХ-д сонсгол танилцуулах хэмжээнд яригдлаа.

Түүний ам нээсэн анхны баримтууд хачирхалтай зүйл ихтэй. Гадаад харилцааны сайдын сайн ажилласны хүчинд далд байсан хар тамхины наймааны хэргүүд илэрч байгаа мэтээр “далийж” эхлэв. Яг үүний өмнөхөн Эрүүл мэндийн сайдын эрчимтэй ажлын үр дүнд сүрьеэг олноор нь илрүүлсэн тухай магтаж, энэ

эрчээрээ тэмбүүг нээж илрүүлээд, түүнтэй тэмцэхээр зориглон орлоо гэх мэтээр хөвөрсөн.

Харин ГХ-ны сайдын хувьд дипломатуудын орооцолдсон энэ наймааны ард байх хязгааргүй эрх мэдэл, хэмжээлшгүй их мөнгийг сөрж, ганцаархнаа эр зориг, тэвчээр зааж зүтгэсээр системийн өөрчлөлт хийж чадсан гэв. 2009 оноос эхэлж дипломат албанд томилогдогсдыг энэ төрлийн гэмт хэрэгт холбогдвол хууль бус наймаанд хамаарах мөнгөн дүнгээр Монгол Улсдаа төлбөр төлөх хатуу нөхцөлтэй гэрээнд гарын үсэг зуруулдаг болсон байна. Тэгэхээр энэ гэрээ ёсоор “Истанбулын хоёр” Германы хуулиар шүүгдэхээс гадна, 70 кг героины үнэ болох гурван сая еврог эх орныхоо нэрийг хугалсны нөхөн төлбөр болгож төлөх ёстой аж. “Энэ чинь ганц Монголын биш дэлхийг хамарсан

МОНГОЛ УЛСААС ХИЛИЙН ЧАНАДАД СУУГАА ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУД

ГХЯ, Консулын газар©



сүлжээ болчихоод байна гэдгийг бодоорой. Би огцрохгүй гэж айсандаа яриад байгаа юм биш. Үүний эсрэг юу хийсэн, ямар арга хэмжээ авснаа л хэлж байна” гэж сайд тайлбарласан байдаг. Сайдын “буянаар” дэлхий дахинаа шившгээ дэлгэсэн Монголын нэр хүнд “цайрах” юм байна л даа.

Хар тамхины наймаа бол дэлхийг хамарсан сүлжээ мөн. Тэд дипломат шугамаар бүтээгдэхүүнээ тээвэрлэхийг чухалчилдаг. Хамгийн аюулгүй, эрсдэлгүй “ногоон гэрэл” бол улсуудын хооронд бүрэн эрхтэйгээр, шалгалт нэгжлэггүй нэвтэрч чаддаг дипломат албаныхан аж. Гэхдээ ядуу буурай орнуудыг онилж, төлөөлөгчийн газрынх нь ажилчдын холбоо сүлбээ, ар гэрийг нь хүртэл бүрэн дүүрэн судалсны дараа тээвэрлэх санал тавьж, ажиллагаандаа оролцуулдаг гэнэ. Истанбулын хоёрын тухайд ч нэгийнх нь гэр бүлд нь хүнд зовлон тохиосон үедээ хар тамхи тээвэрлэх саналд шийдсэн хариу өгч, оролцсон байх магадлалтайг хүрээнийхэн нь ярьж байна. Гэр бүлийнх нь хэн нэгэн өвдөж, олон сая ам.долларын зардалтай хагалгаа хийлгэх шаардлагатай болсныг гэмт хэргийн сүлжээнийхэн мэдэж, “олзолсон” талаар шивнэцгээж байна.

Улсын хөгжил буурай, улс төрчид нь авлигад автсан орнуудын дипломат төлөөлөгчдийн газрын ажилтнуудыг хар тамхины наймаанд татан оролцуулсан тохиолдол зөвхөн Монголоор хязгаарлагдахгүй. Африк, Ази, Өмнөд Америкийн зарим улсын дипломатууд тамхины хэрэгт холбогдсон тохиолдол бий. Хамгийн “алдартай” наймаачид нь Хойд Солонгосын диплома-тууд аж. Дэлхийн түүхэнд дипломатуудын үйлдсэн хамгийн ноцтой 10 гэмт хэргийн жагсаалтад Хойд Солонгосын хар тамхины гэмт хэрэг бичигддэг. 2014 онд АНУ-д гаргасан судалгаагаар сүүлийн 20 жилийн дотор БНАСАУ-ын дипломат ажилтнууд хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл зөөвөрлөсөн, наймаалсан гэмт хэргийн 50 тохиолдол гарсныг дурджээ.

● **Ядуу буурай орнуудыг онилж, төлөөлөгчийн газрынх нь ажилчдын холбоо сүлбээ, ар гэрийг нь хүртэл бүрэн дүүрэн судалсны дараа тээвэрлэх санал тавьж, ажиллагаандаа оролцуулдаг гэнэ.**

● **Гэрээ ёсоор “Истанбулын хоёр” 70 кг героины үнэ болох гурван сая еврог эх орныхоо нэрийг хугалсны нөхөн төлбөр болгож төлөх ёстой аж.**

● **Улсын хөгжил буурай, улс төрчид нь авлигад автсан орнуудын дипломат төлөөлөгчдийн газрын ажилтнуудыг хар тамхины наймаанд татан оролцуулсан тохиолдол зөвхөн Монголоор хязгаарлагдахгүй.**

Бүр 1976 онд “хойдууд” 2.5 сая янжуур тамхи импортлохыг завдсан хэргээс нь үүдэн Дани улс дахь Хойд Солонгосын дипломат төлөөлөгчийн газрыг хааж байв. Түүнчлэн Болгарг баригдсан Хойд Солонгосын хоёр дипломатч 621 мянган ширхэг сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг Арабын орнуудад худалдах зорилготой байв. Үүгээр зогсохгүй тус бүр 20 кг боодолтой нийт 200 кг героиныг Зүүн Европын орнуудад борлуулахаар тээвэрлэж яваад

саатуулагдсан хоёр дипломатын нэг нь улсынхаа эрх ашгийн төлөө хар тамхины наймаа хийх гэж байснаа хүлээсэн гэж АНУ-д мэдээлж байв. Тэднийг дөрөвдүгээр сарын 15 буюу их удирдагч Ким Ир Сений төрсөн өдрөөс өмнө зарж дуусган, мөнгө явуулах тушаал өгсөн тухай америкчууд үнэн худал нь мэдэгдэхгүй зүйл тохуурхан бичиж байжээ.

Төрийн итгэмжлэл өвөрлөж, томилогдсон улсынхаа хуульд нийцүүлэн ажиллаж, амьдрах ёстой дипломатууд нь хүнд гэмт хэргийн холбогдогч болчихоор ингэж тохуурхах нь ч аргагүй. Үүнтэй адил анхны тохиолдолд нь таслан зогсоолгүй, гэмт хэрэгтнүүдээ хаацайлан, татаж авсан даруйдаа суллаж чаддаг Монгол Улсын төрийн институцуудын үйл ажиллагаа нь дэлхийн чихэн шившгээ дэлгэж, гэмт бүлэглэлд олз болохоос яалтай.

Нэг үхрийн эвэр хугарвал мянган үхрийн эвэр доргино гэдэг. 70 жилийн турш 500 гаруй мэргэжлийн дипломатчдийг төрүүлсэн Монгол Улсын Гадаад харилцааны яам, түүнд харьяалагдах бүх албан хаагчийг “хар тамхины наймаачин” болгон харагдуулах хандлага нийгэмд давамгайлж байна. Дипломат протоколд заасныг ёсчлон мөрдөж, үйл хөдлөл, харцаа хүртэл хянаж, гадаад ертөнцөд “нэг амаар” ярьж чаддаг, төрийн элч, чадварлаг дипломатчдын сайн туршлага олон нийтэд бүү хэл ГХЯ-нд мартагдсан гэлтэй.

Гадагшаа харсан Засгийн газар гэж ойлгогддог гадаад харилцааны дипломат ажилтнуудын томилогдох босго, улс төрийн эрх мэдэлтнүүдийн хэтэвчээр хэмжигддэг болсоор удлаа. Эрх баригч намын лидерүүдийн хүслийг гүйцээж, хүнийг нь илгээж амжаагүй байхад хоёрдугаар ээлжийн хачирхалтай томилоонуудыг хийж буй увайгүй үзэгдлээ одоо зогсоогооч. Дүүгээ, хүүгээ, хамаатан саднаа элч болгон томилуулахаар улайрч байгаа шигээ дипломат албыг цэвэрлэж, төрийн өндөр босгыг дахин батжуулахад анхаараач. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



ЗГМ: Зочин



Бид утааг 70-80 хувь бууруулах шинэ технологийг боловсруулсан

Цэвэр нүүрсний нэг шугамтай үйлдвэр барихад 4.5 сая ам.доллар шаардлагатай

◀1

Дээрээс нь нүүрсийг кокс-жуулахад жингийн хорогдол 50 хүртэл хувиар гардаг. Коксжуулсан нүүрсээ барьцалдуулагч хэрэглэж, өндөр даралтаар халаан, шахаж хэвлэнэ. Коксжих явцдаа 50 хувиа алдахаас гадна барьцалдуулж шахмал болгох хүртэл олон шат дамжлагатай учир нүүрсний үнэ нэмэгдэж хэрэглэгчдэд очдог.

Харин бид дэвшилтэт технологиор цэвэр нүүрс боловсруулах судалгааг 2015 онд БНСУ-ын Ёмин технологийн институттай хамтран эхлүүлсэн. Технологийн хувьд байгалийн композит нано бодисыг өөрийн хүрэн нүүрстэй урвалд оруулж, цэвэр нүүрс гаргаж авах юм. Ямар ч нүүрсийг хоёр төрлийн байгалийн гаралтай цайны ханд шиг нано композит материалаар шүршин бүтцийг нь өөрчилж, шатах үед агаарт дэгддэг хорт хий, утааг хүнсэнд нь барьж үлдээдэг түлш гаргаж авсан. Цацлага хэрэглэсэн нүүрсний илчлэг 1000-1500 калороор нэмэгддэг. Багануурын нүүрс 3000 калор илчлэгтэй бол энэ технологийг ашигласнаар гаргах утаа нь буурахаас гадна илчлэг нь 4000-4500 калор болох юм. Нэг айл өвөл таван тонн нүүрс түлдэг байсан бол 3.5 тонн нүүрс түлнэ. Ингэснээр нүүрсний утаа 70-80 хувиар, тоосонцор 10 дахин буурахыг тогтоосон. Одоо нийлүүлэх гэж байгаа “Тавантолгой”-н шахмал нүүрс утааг 50 хувиар бууруулна гэсэн тооцоололтой. Нүүрс түлдэг айл тутамд түлш зарцуулалт 30 хувь багасах, 150-250 мянган төгрөгийн бодит хэмнэлт гарна гэж тооцоолсон.

-Цэвэр нүүрсний үйлдвэрлэлд хэдий хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай вэ?

-Хонгт 100 болон 1000 тонн нүүрсийг шүршиж цэвэр болгох хоёр шугамтай үйлдвэр барихад 4.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Манай улсын хэмжээнд гурван шугам байхад эрэлтээ хангах боломжтой.

-Цэвэр нүүрсийг зах зээлд нэвтрүүлэх талаар хэрхэн ажиллаж байгаа вэ?

-Туршилт судалгаагаа хийж, холбогдох байгууллагуудад

танилцуулсан. Шүршиж, хатааж, шатааж үр дүн нь ямар байгааг үзүүлсэн. “Өө сайхан юм байна” гээд тийм байгууллагад хандаарай гэж хэдэн тийшээ хэсэг гүйлгэдэг юм. Судалгаа шинжилгээний ажил ихтэй бидэн шиг хүмүүст өдөр шөнөгүй гүйгээд байх зав байхгүй. Гэхдээ л сэтгэл зовоод хөөцөлдөж үздэг. Хурал цуглаан, уулзалт бүр дээр хэдэн эрдэмтэн, судлаачид нь үгээ хэлдэг. Тоож сонсдог хүн ховор. Нэг л өдөр Монгол Улс хүний оюуны өмчийг тоодог болох цаг нь ирэх байх.

-Нийслэлд түүхий нүүрсний хэрэглээг хориглосон энэ үед та бүхний бүтэц хэргээ гаргах боломжтой санагдаж байна?

-Монгол Улсын Засгийн газар энэ оны тавдугаар сарын 15-наас эхлэн Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглох шийдвэр гаргасан. Төр өөрөө шахмал түлш боловсруулахад оролцож, хэрэглэгчдэд түүхий нүүрсний үнээр зарна. Нүүрсийг тээвэрлэнэ, сайжруулна гэх мэтээр нэмүү өртөг шингээж байгаа учраас түүхий нүүрсний үнээр зарвал алдагдалтай. Үүнээс гадна нийслэлээс 500 гаруй км зайтай “Ухаа худаг”, “Тавантолгой”-гоос түүхий эдээ тээвэрлэнэ.

Сайхан юм бэ, эрдэмтэн, судлаачдаа ямар сайн дэмждэг юм гэж атаархам улс зөндөө байна

Шахмал түлшний үнэ ямар байхыг зах зээл биш төр тодорхойлж, нэг байгууллагад хэтэрхий их давуу тал олгож, монополь үүсгэж байгаад бид шүүмжлэлтэй хандаж байгаа. Монопол үүсгэлгүйгээр олон талын санал санаачилгыг хэрэгжүүлж, өрсөлдөөнийг чөлөөтэй хангах ёстой. Энэ өвөл үр дүн нь харагдах байх. Нарийн мэргэжлийн мэдлэг туршлага гэдэг хэн нэгэн дарга болонгуутаа эзэмшихдэг зүйл биш. Тиймээс эрдэмтэн судлаачдынхаа үгийг сонсож, судалгаа шинжилгээтэй ажиллавал сайн. Төрөл бүрийн мэргэжлийн, янз бүрийн салбарын хүмүүс үзэл бодлоо уралдуулж байж зөв гарцыг олно. Өчнөөн газраар явж, олон жилийг зарцуулан суралцаж ирсэн эрдэмтэн, судлаачид өвөртөлж ирсэн.

-Та Ломоносовын нэрэмжит

их сургуульд суралцаад Москвагийн Технологийн их сургуульд зэрэг хамгаалсан. 2000 оноос хойш арван жил БНСУ-ын их, дээд сургуулиудад эрдэм шинжилгээний ажилтан, багш хийсэн төдийгүй дундуур нь бас хэдэн жил Япон, БНХАУ-д суралцаж, ажилласан юм билээ. Өөрийн улсын нөхцөл байдлыг ажиллаж байсан улс орнуудтайгаа харьцуулж үзвэл манай улс шинжлэх ухааныг хэр дэмждэг гэж бодож байна?

-Монгол Улс эрдэмтэн судлаачдаа ашиглаж чаддаггүй. Дэмжээд ашиглавал үйлдвэрлэгч болох боломжтой шинийг санаачлагч, шинжлэх ухааны салбарын олон эрдэмтэн судлаачид бий. Бидэнд бүтээх зүйл их байна. Банкнаас хүүтэй мөнгө зээлээд бага багаар урагшилж байгаа. Гэхдээ энэ янзаараа бол их удаан хөгжинө. Төрөөс дэмжлэг үзүүлдэг ч энэ нь хангалттай биш. Зөв бодлоготой, зөв чиглэлтэй байх хэрэгтэй.

Ямар сайхан юм бэ, эрдэмтэн, судлаачдаа ямар сайн дэмждэг юм гэж атаархам улс зөндөө байна. Миний бодлоор Япон, Солонгос бол эрдэмтдийнхээ судалгааг бүтээл болгож чаддаг улс. Сүүлийн үед хятадууд “Мөнгө нь энэ байна. Алив санаа чинь хаана байна” гэдэг болсон. Харин манайх “Санаа нь энэ байна. Мөнгө нь хаана байна” гэдэг. Судалгаанд суурилсан бизнесийн санаа, хөрөнгө оруулалт хоёр хосолж байж инновацад суурилсан эдийн засаг хөгжинө.

Бид Багануурын шинжлэх ухаан технологийн парк гэж өчнөөн жил ярьж, зөндөө бичиг баримт боловсруулсан. Одоо хүртэл шийдэгдэхгүй, бодитоор ажил хэрэг болоогүй л байна. Өнөөдөр бид юу үйлдвэрлэж байгаа юм бэ. Социализмын үед томоохон үйлдвэрүүд байсан. Одоо бол түүхий эдээ л зарж амьдардаг улс болсон.

-Та тамедин нэрийн 20 гаруй бүтээгдэхүүн, санитол ариутгал халдваргүйжүүлэлтийн бэлдмэл зэрэг өргөн хэрэглээний олон бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нэвтрүүлсэн. Мөн адууны калыци болон бусад нэр төрлийн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд амжилттай гаргаж байна. Бизнесийн санаагаа хэрхэн олж, хэрхэн амжилттай хэрэгжүүлсэн бэ?

-Би Японд суралцаж байхдаа хагалгаанд орсон юм. Хүний газар байгаа хүн удаан өвдөж болохгүй гэж бодтол олгойн хагалгааны дараа чанартай ариутгалын бодис хэрэглэж байсан учир хурдан эдгэсэн. Үүнийг хэрхэн хийгээд байна вэ гэж судалсаар мэдэж

ирээд Монголдоо “Тамедин” цувралаа анх удаа бүтээсэн. 1993 онд санаагаа боловсруулаад ирсэн боловч таван жил хөөцөлдсөний эцэст 1998 онд “МонХимо” компани үйлдвэрлэлд нэвтрүүлж байлаа. Бүхэл бүтэн таван жилийн хугацаа алдсан гэж бодохоор харамсалтай байдаг. Санаагаа орхих бодол ч төрж байсан боловч, тууштай явсаар бүтээл болгосон.

Үүний дараа Солонгос улсын нано кальцийг бүтээсэн багт

ажилласан. Манай баг далайн амьтны яснаас кальци гаргах ажлыг эрхэлдэг байсан. Гэхдээ манай улсад далайн амьтан байхгүй учраас хамгийн сайн чанарын ястай адууны яснаас кальци гаргах ажлыг эхлүүлсэн. Далайн амьтнаас илүү үр дүнтэй гэдгийг тогтоосон учраас судалгаагаа хийсэн.

Ер нь санаа гэдэг амьдралаас урган гардаг. Бизнесийн санаа энгийн жижиг зүйлээс л төрдөг юм. Тиймээс залуучууддаа хүсэл

мөрөөдөлдөө тууштай байгаарай гэж захимаар байна. Ажигч гярхай, дээрээс нь мэдрэмжтэй байхад жижигхэн зүйлээс л том бүтээл гаргана. Үүнийг яаж хийдэг юм бол, энэ яагаад ийм байгаа юм бол гэсэн асуултаас санаа төрнө. Хүнд хэчнээн ч санаа төрж болно. Үүнийгэ сайн тэмдэглэж авах хэрэгтэй. Тэмдэглэхгүй бол мартагддаг.

-Та “МонХимо” үйлдвэрээ яг л “тэг”-ээс эхлүүлсэн үү?

-Нэгдүгээр эмнэлгийн жижигхэн өрөөнд нэг литрийн савтай 10-20 бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байсан “МонХимо” үйлдвэр өнөөдөр хэд хэдэн лабораторитой, өнөр өтгөн хамт олон болж өргөжсөн байна. Өдөрт хэдэн мянган бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсон. Шинжлэх ухаанд суурилсан компанийн давуу тал нь тогтвортой, аажим аажимдаа хөгжиж, улам боловсронгуй болдог юм. Аливаа улсын хөгжлийн тулгуур нь шинжлэх ухаан, технологийн хөгжил байдаг. Судалгаанд суурилсан бүтээл, бүтээгдэхүүн нь өрсөлдөх чадвар өндөртэй, ямагт хөгжин дэвшиж байдаг. Хэрэгжүүлбэ гэвэл маш олон санаа бий.

Хэдэн мянгаараа хаягдаж байгаа түүхий эдүүдийг хараад харамсдаг. Манай улс жилд доод

тал нь 200 мянган адуу идшиндээ хэрэглэдэг. Нэг адуунаас дор хаяж 20 кг яс гарна. 4000 тонн ясны нөөцөөс бид 100 тонн хүрэхгүйг л хэрэглэж байна. Цаана нь ямар их нөөц боломж байгаа гэж санана. Казахстан, ОХУ зэрэг таван оронд адууны ясны кальцаа экспортлох зөвшөөрлөө авчихаад буй. Түүхий эдээ боловсруулаад, гадаадын зах зээлд гаргавал манай эдийн засагт ч хэрэгтэй.

-Ярилцсанд баярлалаа. [ЗГМ]

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ нь “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёрдахь үе шатны явцад хөндлөнгийн үнэлгээ хийлгэх тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Зөвлөхийн тендер шалгаруулалтыг бага үнийн аргаар зохион байгуулна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёрдахь үе шатны хэрэгжилтийн явцыг /Вус, Дундговь, Сүхбаатар/ аймгуудад тус хөтөлбөрөөс дэвшүүлсэн зорилтын биелэлтэд хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэх болно. Үүнд:

- Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх,
- Малыг ээмэгжүүлэх ажлын гүйцэтгэл,
- Бүс нутгийн онцлог, ашиг шимийн чиглэлээс хамаарч малын төрөл хоорондын харьцаа,
- Сүргийн зохистой (харьцааг) бүтцийг бүрдүүлж эдийн засгийн хөшүүргийг бий болгосон ажлын гүйцэтгэл,
- Бэлчээрийг зохистой ашиглах менежментийн нэгдсэн системийг бий болгож, дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, бэлчээр нутгийн ашиглалт, кадастрын зураглалыг бүс, аймаг, сумаар гаргаж, тухайн нутагт байх боломжтой малын тоо, төрлийг тогтоож, мэдээллийн сан бий болгох ажлын гүйцэтгэл,
- Мал сүргийг бруцеллёз, адууг ям, халдварт цус багасах, үхрийг лейкоз өвчнөөс бүрэн эрүүлжүүлсэн ажлын гүйцэтгэл,
- Мал эмнэлэг үржлийн тасгийн (Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг) үйл ажиллагаа болон хөтөлбөр, арга хэмжээний биелэлт

3. Мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга;
- Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар;
- Судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлын чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан ажлын талаарх туршлага;
- Судалгаа, шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019.06.18-ны 11 цаг 00 минутын хооронд авч болно. Тендерийг цахимиар зохион байгуулж байгаа учир 2019.06.20-ний өдрийн 11 цаг 00 минутын дотор WWW.TENDER.GOV.MN сайтаар ирүүлнэ үү.

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ 16А, ЗАСГИЙН ГАЗРЫН 9 ДҮГЭЭР БАЙР, А КОРПУС, ХХААХҮЯ-НЫ 404 ТООТ ӨРӨӨ. УТАС: 261691

Үзэл бодол



ОУВС байгалийн баялагтай орнуудыг онилж ангуучилдаг

И.Цэрэнхүү
Социологич, памфлет нийтлэлч

ОУВС бол библид гардаг албин чөтгөр биш гэж тус сангийн ерөнхийлөгч Кристин Лагард хэлсэн удаатай. Үнэн хэрэгтээ ОУВС жинхэнэ албин чөтгөр юм. Энэ чөтгөр байгалийн баялагтай улс орнуудыг онилон ангуучилдаг. Эдийн засгийг нь олон жилээр туйлдуулж өрөнд оруулдаг. Улмаар дефолт зарлах хэмжээнд хүргэж байгаад авралын бурханы дүр эсгэж, зээлийн хөрөнгөөр булж, баялагийг сордог ийм л байгууллага. ОУВС-гийн аливаа хөтөлбөрт орсон орны ард түмэн ядуурал хоосорч, хэдхэн тооны хүн л хагартлаа баяждаг нийтлэг дүр зураг ажиглагддаг.

Тухайлбал, Аргентиныг эдийн засгийн дампуурлын ирмэгт хүргэж байгаад 50 миллиард ам.долларын зээл олголоо. Украинaar хичнээн жил тоглов. Харин одоо тус улсад их хэмжээний хөнгөлттэй зээл олгох гэж байна. Венесуэлийг мөн дампууралд унагаж байгаад нэг тэрбус ам.долларын зээл олгохоор шийдлээ.

Хамгийн сүүлд буюу энэ сарын 7-ны өдөр Боливийн ерөнхийлөгч Эво Моралесын хэлсэн үгийг ямар нэгэн нэмэлт хачиргүйгээр энд ишлэлээ.

“Баялгийн хуваарилалтын тэнцвэргүй байдал гүнзгийрч, баян хоосны ялгаа өдрөөс өдөрт мэдэгдэхүйц хэмжээгээр өссөөр байна. Харамсалтай нь ОУВС улам бүр хаалттай бодлого явуулах болжээ. Цөөнхийн гарт нэгэнт төвлөрсөн мөнгөн капиталыг тэтгэж, олинхыг ядуурлын ангал руу түлхэж байна. Хувьчлалаа зогсоо, ард түмэнд баялагтаа эзэн байх эрхийг нь олго. Энэ шаардлагыг хүлээж аваагүй нөхцөлд Боливийн ард түмэн ОУВС-гийн эсрэг босоход бэлэн байна. Бид шударга ёс тогтоохын төлөө тэмцэх болно” гэж мэдэгдлээ.

Монгол Улсын эдийн засгийн байдал бас иймэрхүү л байгаа. Манай гадаад өр 18 тэрбум ам.долларт хүрлээ. Дараа жилээс өрийн дарамтыг мэдэрч эхэлнэ. Бид “Оюутолгой”-гоос ашиг авч чадахгүй л байна. Учир нь үүний ард ОУВС зогсчихоод, хөдөлгөхгүй байна. Монголын төр асуудлыг бодитой авч хэлэлцэх бодолгүй байгаа. “Оюутолгой”-г нэн яаралтай авч хэлэлцэхгүй бол бид Боливийн араас орох эрсдэл үүсч байна.

УИХ, Үндсэн хуулинд өнгө будгийн засал хийх нэрээр “Оюутолгой”-н асуудлаас бултах санаа гаргаж байгаа. Монгол Улсын төрийн тэргүүн нэг танхимаас нөгөө танхим руу албан бичиг шидэхээс цаашгүй байна. Засгийн газар “Оюутолгой”-н талаар баримтлах бодлого дээрээ танхим дотроо саналын зөрөлдөөнтэй, зөрчилтэй байна. Асуудал маш ноцтой болох байдал үүслээ. ОУВС-гийн асуудал “Оюутолгой”-той шууд холбоотой шүү гэдгийг би хоёр жилийн өмнө гарган тавьж байсан. sonin.mn/blog/tse-genkhuu/77988

Цаг үеийн шаардлагаар бло-гоос гарган, дахин нийтэлж байна.

ОУВС ҮҮССЭН ТҮҮХ

ОУВС нь агуулгаараа, гагцхүү АНУ-ын эрхшээлд байдгаараа онцлог байгууллага. Энэ тухай зориг гарган шүүмжилсэн хүний нэг нь Хятадын өмнөө барьдаг, нэрт эдийн засагч профессор Ши Цзяньсюнь. Энэ эрхэм, Хятадын есөн их сургуулийг дэлхийн



Валютын "албин чөтгөр"

тэргүүлэх төвшинд гаргаж чадсан “985” төслийг хэрэгжүүлэгч, дэлхийн хүн. Бээжингийн Их сургуулийн 100 жилийн ойгоор, тухайн үеийн Хятадын удирдагч Цзянь Цзэминий дэвшүүлсэн төсөл л дөө.

Гэрээ байгуулсан улс орнуудад голдуу иргэний дайн болоод дуусдаг

Бээжийнгийн их сургуулийг 1898 оны тавдугаар сард үндэслэн, эндээ “төсөл 985” хэмээн нэрлэсэн байх. АНУ-ын зүгээс ОУВС-д оролцох квотоо эргэж харах болсон тухай мэдэгдсэний дараа Ши Цзяньсюнь, “Квотыг өөрчилснөөр суурь хүрээний доторх нэг талын нөлөөлөлд өөрчлөлт гарахгүй. АНУ-ын оролцооны хүч хэвээр үлдэх болно. ОУВС-г Америк удирдсаар ирсэн, цаашид ч удирдах болно” гэж хэлсэн байдаг. Энэ үгний ард дэлхийд БРИКС банкны нэрийг өргөх, ОУВС-д Хятадын нөлөөг ахиулах хятад бодлого зогсож байгааг үгүйсгэхгүй.Гэхдээ л гол нь квот биш далд систем байна гээд үнэнийг нээлттэй хэлчихсэн нь олзуурхууштай. Аливаа Институцын чадал, үйл ажиллагааны чиглэл нь үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдийн эрх, оролцоогоор зохицуулагдаж байдаг нь ойлгомжтой юм. ОУВС-гийн анх үүссэн түүхийг товчхоон гүйлгэн харцгаая.

IMF (International Monetary Fund) гэх НҮБ-ын эрхшээлд байдаг банк, санхүү зээлийн агентын нэрийг оросууд “Международный валютный фонд” хэмээн утга гуйвуулан орчуулсан. Харин үүнийг монголчууд орос хэлнээс ОУВС хуүлдэг байгууллага юм. Албан ёсны зорилго нь...хөгжиж яваа улс орныг санхүүгийн хямралаас гаргах, туслах... энээ тэрээ гээд жигтэйхэн гоё тайлбартай. Бачир дээрээ нохойн жогор. Төлбөрийн чадвараа алдсан олон ч орныг чөтгөр шиг айлган тамлаж, сүйрлийн ирмэгт аваачсан даа.

ОУВС анх 1947 оны гуравдугаар сарын 1-нд үндэслэгдсэн гэж албан баримт бичгүүддээ тусгасан байгаа. Үнэндээ бол Дж.Кейнс, Гарри Уайт... зэрэг

эдийн засгийн том онолчдын санаачилгаар дэлхийн зартай, зангарагтай хөрөнгөтнүүд 1944 оны зургадугаар сарын 22-нд америкийн жижигхэн хот Бреттон-Вүүдэд цуглан, хувь хөрөнгө гарган сан байгуулж мөнгө хүүлэх зарчмыг тохиролцсон байдаг. Тэр нь ОУВС-гийн “Хартын зүйл ангиуд” нэрээр түүхэнд үлджээ. Төлбөрийн чадвараа алдсан хөгжиж буй орнуудын ард түмний халаамыг хоослон, улсыг нь сүйрэлд оруулах механизм, далд санаа, зарчмууд нь бүгд Хартын зүйл ангиудаар биеллээ олж байдаг юм. Улс орнуудад үймээн самуун, замбараагүй байдал үүсгэнгүйт л мөнгөн капиталын урсгал Хартыг үндэслэгчдийн банк руу цутгадаг уран механизмыг урьчилан маш сайн тооцоолон бодож олсон байдаг. Энэ бол ердийн санхүүгийн луйвар юм. Харин үүнийг дэмжээд гар хөл нь болоод явдаг шуналын донтой өөдгүй новшнууд аль ч улс орноос олдоод байдаг нь гайхалтай.

ОУВС-ГААС ЗЭЭЛ АВААД БАЛАРСАН ОРНУУД

ОУВС-гийн дөрвөн төрлийн зээлийг хамгийн хүнд нөхцлөөр гэрээ байгуулсан улс орнуудад голдуу иргэний дайн болоод дуусдаг. Манайх энэ замаар явж байгаа. Үнэмшилтэй ойлгогдох талыг нь бодоод хэдэн жишээ орууллаа.

1. Югослав. Социализмын үед ч зах зээлийн эдийн засгаараа гайхуулдаг, тэрийгээ чадамгай удирддаг нэр зүстэй, хөгжилтэй орон байснаар нь монголчууд андахгүй.

Югославт, ОУВС-гаас зээл олгохдоо ер бусыннэг нөхцөл тавьсан байдаг. Тэр нь бүсийн чанартай биеэ даасан эдийн засгийн мужлалыг тэнцвэртэй барих төрийн бодлогоосоо татгалзах явдал байв. Югослав, ОУВС-гийн зөвлөмжийг хэрэгжүүлнэ гээд зээл авсан. Улмаар орон нутаг төрийн хяналтаас гарч цонтой байдал үүсэн, иргэний дайн дэгдэж 600 мянган хүний аминд хүрсэн. Нэгдсэн Югослав Улсын үндэсний мөнгөн капиталийн 80 хувь нь Америкийн банк руу шилжсэн баримт бий.

2. Саяхныг болтол “ХАА хөгжлийн загвар, модель” хэмээн тооцогдож дэлхийг гайхуулж байсан Руанда гэж жижигхэн улс зүүн Африкт бий. Гэхдээ одоохондоо байгаа.

Руанда, 1989 онд цаг агаарын хүндрэлээс болж ургац алдан ОУВС-гаас асар их хэмжээний зээл авсан. Гай газар доороос гэгчээр дараа жил нь дэлхийн кофены үнэ унасан. Унагасан

байх ч магадлалтай. ОУВС дахин зээл авахыг зөвшөөрсөн, гэхдээ ганцхан нөхцөл тавьсан байдаг юм. Тэр нь фермерүүдэд төрөөс дэмжлэг үзүүлдгээ бүр мөсөн зогсоох явдал байв. Ард түмэн энэ нөхцлийг зөвшөөрөөгүй. Гэтэл төрийн түшмэдүүд толгой мэдэн зөвшөөрсөн.

Төрд шургалсан олигархи тутси нар, газар тариалан эрхэлдэг хүн амын олонх туту нарын хооронд байсан хэдэн зууны эвдрэлцлийн шарх гэнэт сэдэрч, төр ард түмний хооронд ойлгомжгүй байдал үүсэн иргэний дайн дэгдсэн. Улмаар 1.5 сая руандачуудын аминд хүрсэн гашуун түүхийг хүн төрөлхтөн мартаагүй байгаа. Иргэний дайнаар улс орны мөнгөн капитал бүхэлдээ Америкийн банкууд руу урсч, юу ч гүй болтлоо сүйрсэн ХАА-н фермерүүд гадны баячуудад эдлэн газраа худалдаад хэдэн зуун мянгаараа дүрвэж эхэлсэн.

● **Өнгөн дээрээ АНУ залаад байгаа дүр эсгэдэг ч үнэн чанартаа хэдхэн гэр бүлийн эзэмшилд байдаг.**

● **Жишээлээд бодоход, Монголыг хэд хуваачихъя, газар доорх баялгийгнь ховх цөлмөчихье гэсэн солиотой санаа гарган хэрэгжүүлэ гэвэл Бильдэрбергийн клубын нөлөө бүхий хэдхэн хүний хуйвалдаан л хангалттай.**

● **Одоо Монголд Орос руу байдаг хүчээрээ ойртохоос өөр зам үлдээгүй гэж нийгэм зүйн асуудал сонирхдог мэргэжилтний хувьд бодож байна.**

3. Сомали. Эффиофтой хийсэн дайны дараа санхүүгийн төлбөрийн чадвараа алдаж, ОУВС-д хандсан байдаг. ОУВС мөн л нэг болзол тавьсан нь “хахир Эдийн засаг” төслийг хэрэгжүүлэх санал. Ингэхдээ америкийн үр тариаг демпингийн үнээр худалдаж авах гэсэн хатуу болзол.

Ийнхүү газар тариалан эрхэлдэг байсан хоршоо, өрхийн аж ахуй үй олноороо дампуурч үндэсний орлого хумигдан эмнэлэг, цэцэрлэгүүд хаагдан буудалд нууцаар уулзаж Дэлхийн Засгийн газар байгуулах шийдвэр гаргасны дараа Оросын Думын хуралдаан дээр В.Жириновский... хуудрагаар Дэлхийн далд Засгийн газрын мөрөөдөл биеллээ оллоо. Тэд ядуу буурай орнуудад хямд зээл өгөөд газар нутгийг нь барьцаалж байна. Чубайс, Каспаров, Гуриев нар хүртэл тэнд доншуучилж явна... гэж хашхирч байв.

4. Латин америкийн зарим ор-

ныг ОУВС яаж балласан талаар Мексик, Аргентины түүх мөн харуулна.

Мексик Улс 1994 онд санхүүгийн хямралд орон, төлбөрийн чадваргүй болсноо зарласан. ОУВС-гаас 53 тэрбум ам.долларын зээл олгохдоо тавьсан болзол нь тус улсыг NAFTA (АНУ Канадын худалдааны чөлөөт бүс)-д хамрагдах нөхцөл юм. Ингэснээр Мексик чөлөөт бүсэд 14-16 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, орлогыг бас л Америкийн банкаар дамжуулсан. Мексикийн жинхэнэ там эндээс эхэлсэн байдаг юм. Түүхэнд байгаагүй ядуурал нүүрлэж, ажилгүйдэл гэмт хэрэг гарсан. Нийт нас барагчдын 51хувь нь өлсгөлөнгөөр цааш харсан гэсэн баримт байгаа.

Аргентин гэж ямар сайхан орон байлаа. Өнөөдөр ямар байдалд ороод байна вэ. Эдийн засгийн түр зуурын хямралаас гаргаж Аргентины гайхамшиг гэгчийг бүтээн босгоно гэж амласан ОУВС-гийн төлөвлөгөө, “Хүнд өвдөлтийн эмчилгээ” төсөл биеллээ олоогүй. 1989 оноос эхэлсэн ОУВС-ийн эрүүлжүүлэх хөтөлбөрөөр олгосон зээл нь өнөөдөр 138 тэрбум ам.долларын өр болон хувирлаа. Цалин, тэтгэвэрээ ч өгч чадахгүй, сангаар нь өрөө төлж байна. Америкаас оруулсан 40 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын орлого Америкийн дансаар эргэж, нийт 280 тэрбумын ашиг болон өсчээ.

ДЭЛХИЙН ЗАСГИЙН ГАЗАР

184 гишүүн улстай, 3000-аад нууц туршуултай мөнгө хүүлэх, санхүү зээлийн хувь нийлүүлсэн институт ардаа залах эзэнгүй оршин тогтнох боломж байхгүй. Өнгөн дээрээ АНУ залаад байгаа дүр эсгэдэг ч үнэн чанартаа хэдхэн гэр бүлийн эзэмшилд байдаг.

Тэрийг далдаас удирддаг Засгийн газартай, тэр нь Ротшильдын санаачилгаар анх бий болсон “Бильдэрбергийн клуб” бололтой байдаг. Учир нь, ОУВС-гийн ерөнхийлөгч Кристин Лагард энэ бүлэглэлийн албан ёсны гишүүн хүн. Бильдэрбергийн клуб Рокфеллэр болон дэлхийн нөлөө бүхий баячуудын нууц дөрвөн бүлэглэлтэй нэгдэх талаар үгсэн тохиролцож Австрийн Interlpen буудалд нууцаар уулзаж Дэлхийн Засгийн газар байгуулах шийдвэр гаргасны дараа Оросын Думын хуралдаан дээр В.Жириновский... хуудрагаар Дэлхийн далд Засгийн газрын мөрөөдөл биеллээ оллоо. Тэд ядуу буурай орнуудад хямд зээл өгөөд газар нутгийг нь барьцаалж байна. Чубайс, Каспаров, Гуриев нар хүртэл тэнд доншуучилж явна... гэж хашхирч байв.

Жишээлээд бодоход, Монголыг хэд хуваачихъя, газар доорх баялгийгнь ховх цөлмөчихье гэсэн солиотой санаа гарган хэрэгжүүлэе гэвэл Бильдэрбергийн клубын нөлөө бүхий хэдхэн хүний хуйвалдаан л хангалттай. Механизмыг нь тэд хоромхон зуурт олж чадна. Бильдэрбергийн хуйвалдаанаар тухайлбал, 1974 онд Р.Никсоныг, 1990 онд Маргарет Тэтчерийг огцруулж, Б.Обамаг Х.Клинтонтой хамтрахыг шийдэж, Иракийн дайныг жилээр хойшлуулж, Югославыг хэдэн хэсэг болгон хувааж, Украиныг Оростой сөргөлдүүлж чадаж байв. Монгол Улс, мунхаг төрийн харгайгаар ийм л нэг аймшигтай чөтгөрийн саварт өөрийн эрхгүй гүйгээд орчихлоо. Бильдэрбергийн клуб 60 жил оршин тогтнохдоо 62 удаа хурал хийсэн. Гэхдээ юу ярыгаасан, ямар асуудал шийдсэнийг, тэр ч бүү хэл хаана хуралдсаныг нь Дрезден, Австри хоёрт болсныг эс тооцвол дэлхийн хэвлэл мэдэж чадаагүй.

Харин Оросын КГБ багагүй мэдээллийг ил болгосон байдаг юм билээ.

Одоо Монголд Орос руу байдаг хүчээрээ ойртохоос өөр зам үлдээгүй гэж нийгэм зүйн асуудал сонирхдог мэргэжилтний хувьд бодож байна. Учир нь Дэлхийн засгийн газрын зүгээс Монголын газрын хэвлий дотоорхыг ховх сорохоор онилсон харцаа урд хөршөөр хослуулаагүй гэх баталгаа байхгүй юм.

ОУВС-ГААС ЗЭЭЛ АВАХГҮЙ УРАГШЛАХ ЗАМ БАЙСАН, ЦААШИД Ч БАЙГАА

ОУВС-ийн чөтгөрийн санаатай хүндрүүлсэн хөтөлбөрт орохгүйгээр эдийн засгаа эрүүлжүүлэх арга байсан уу? гэвэл байсан. Одоо ч тэр боломж байгаа.

Гагцхүү тэр нь эх оронд ашигтай ч улстөрчлөд ашиггүй. Гэхдээ монголчуудын МОНГОЛ гэсэн нийтлэг эрх ашиг тархинд биш цусанд нь генээр хадгалагдан оршдог. Тэгээд ч Руандад хаа нэгтгээгээс нүүдэллэн бэдэрч ирсэн хуту, тутси нартай жишиж арай ч болохгүйгэдгийг дутуу л ойлгоцгоогоод байна.

ОУВС, түүний ард зогсож байгаа ҮДК-дын үйлдлийг сөрөн зогсож чадах цорын ганц хүч бол Хятад биш. Харин Орос. Ерөнхийлөгчийн дэргэд Орос-Монголын хамтарсан ГЕО судалгааны хүрээлэн яаралттай байгуулж зарим онцгой эрхийг олгох гарцыг судалмаар байна. Үндэсний аюулгүй байдлын асуудлаар харилцан тусалцах хэрэггүй зарим онцгой эрхийг олгох гарцыг судалмаар байна. Үндэсний аюулгүй байдлын асуудлаар харилцан тусалцах хэрэггүй зарим онцгой эрхийг олгох гарцыг судалмаар байна. Шүүмжлээд зогсохгүй гарч хайлцах үүднээс иймэрхүү санаагаар төгсгөлөө, санаа оноогоо уралдуулцгаана уу!

Chocolate production rises in Mongolia following global markets

In 2018, USD 332,000 worth chocolate products were exported.

World Bank: Mongolia scores 3.4 points on policy and institutional assessments

Mongolia received a rating of 3.3 points in 2017 and 3.2 in 2016.

Sharyn Gol JSC plans to sell 1.82 million tons of coal

Coal production of the company rose 2.4 percent to 1.08 million tons in 2018.

Top 20 index falls 0.09 percent to 19,688.16 points

Market cap stands at MNT 2.46 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS


President of Mongolia Battulga Khaltmaa to pay an official visit to Kyrgyzstan on June 12 at the invitation of the President of Kyrgyz Republic Sooronbay Jeenbekov. The President will be attending the Shanghai Cooperation Organization Summit in Bishkek on June 13-14.

ECONOMY

As of the first five months of 2019, about 452,000 new securities accounts were opened, of which 60 percent were in March. Accounts opened by the foreign investors rose by 50 percent compared to the same period in 2018.

Oyu Tolgoi LLC, one of the largest domestic employers, reports that the frequency of injuries in the first quarter of 2019 was the lowest in Rio Tinto Group.

Top 20 index falls 0.09 percent to 19,688.16 points. MSE A index decreases 0.19 percent to 9,057.48 points. MSE B index drops 0.54 percent to 7,807.15 points. Market cap stands at MNT 2.46 trillion.



SOCIETY

AmCham Mongolia, in collaboration with The Wicks Group, organized a successful aviation week from to initiate a discussion on Launching Direct Air Carrier to the United States. Currently, MIAT Airlines has extensive room for improvement in their specialized workforce, technical expertise, and operational security to fully qualify for FAA assessments. The seventh Altan Khalis International Film Festival kicks off on June 8 and the winners were announced.

Trucks to transport coal via Tavantolgoi-Gashuunsukhait road have been showcased at the Ministry of Road Transport Development of Mongolia. Digital Business Conference to be held at the National Information Technology Park in June 14.

Scan the QR code for further information and to purchase the ticket.



Transit freights on the rise amid growing trade between Russia and China



The length of the railway line connecting Mongolia to Russia and China is 110 km long.

Gerelchuluun. J / ZGM©

Annual transit freight reached 3.4 million tons

Aminaa.U
ZGM

Mongolia’s shipping link with the shortest route from the West to the East has risen the transportation turnover. Last year, the num-

ber of transit containers passing through Mongolia increased by 53 percent to 855 freight trains. It is almost five times more than two years ago.

Officials reported that transit transportation reached 3.4 million tons a year. In recent years, exports and imports are continuing to increase and transportation volume is on the rise, railway transportation has grown by 15 percent to MNT 616 billion as of 2018.

However, the capacity of Mongolia’s transportation has reached

its peak and the spokesman of the Ulaanbaatar Railway JV said “Our capacity to receive and transport reached its peak. Now it is time to make technological innovations”. The international delegations also acknowledged this. “The transit route was relatively slow in 2017 but increased sharply after the 2018 Beijing meeting. However, we are worried that there will not be enough capacity to receive this while the freight is increasing. The volume of transit cargo from Russia to China is rapidly rising,” said

the Secretary-General of the International Railtransport Committee.

Certain proportion of trade turnover has to come to Mongolia

In 2018, the number of transit transportation routes from Rus-

sia to Asia to the port of Erlian via Mongolia hiked; Mongolia accounts for 90 percent of the total transit shipping order. It is expected to increase continuously.

The length of the railway line connecting Mongolia to Russia and China is 110 km long. It is 533 km shorter than the Kazakhstan transit railway and 748 km closer than the Trans-Manchurian corridor. Therefore, a certain proportion of trade turnover has to come to Mongolia, which has led to the peak load. [ZGM]

MARKETS

Chocolate production rises in Mongolia following global markets

The domestic production of chocolates and cocoa inputs is improving. Mongolia, which has only been importing these types of products from overseas, started exporting to foreign markets in recent years. In 2018, USD 332,000 worth chocolate products were exported according to the Customs Office.

According to the Ministry of Food, Agriculture and Light Industry, Mongolia currently supplies less than 10 percent of domestic demand for chocolate. Most of the chocolates are imported from Ukraine, Belgium, the USA, and Japan.

Esun Od Food International LLC, best known for its “Altan

Gobi” brand, produces about 50 types of food products and exports four of them to Japan. The company has the capacity to produce five tons of products per day at full capacity, and its sales increased 60 percent this year over the previous year.

In addition, Devjikh Javkhant, produces “Golden Gerege” chocolate shaped like Mongolian tugriks, is aiming to stay stable in the market and make new products. Our manufacturers import their raw materials from overseas. In addition to the main raw materials, cocoa, nuts, and dried fruits are obtained from European countries. The producers try to buy seabuckthorn,

cranberry, and barley flour.

However, the lack of necessary equipment and technology are becoming a challenge, due to which the production capacity remains weak. Specifically, most of the companies operating in Mongolia are semi-automated and make hand-made production that challenges the domestic market. Mongolian chocolate is manufactured by European technology, so it can be competitive in Asian countries.

Mars, produces sweets such as M&M’s, Snickers, and Dove, made half of its total external sales from China in 2017. The tariff barriers of China on the U.S goods are expected to increase the competitive-



ness of other countries. As a result, there will be a space for regional producers.

More importantly, the Asian producers of cocoa bean raw materials have failed to meet the demand for commodities, so imports from

Africa and South America have grown dramatically. In the past four years, cocoa bean processing grew 25 percent in Asia and reached 780,000 tonnes in 2018, according to the Asian Kakao Association. [ZGM]

MINING

Sharyn Gol JSC plans to sell 1.82 million tons of coal until June 2020



Mongolian Stock Exchange (MSE) tier-II listed Sharyn Gol JSC plans to sell 1.89 million and 1.82 million tons of coal in June 2019-2020, according to its operations report.

The company supplied a demand for power plants in the northern region of Darkhan and Erdenet in 2018 and supplied 75-80 percent of its coal to energy consumption. Last year, coal production of the company rose 2.4 percent to 1.08 million tons.

The company's sales rose 3.5 percent to 1.07 million tons. Total revenues declined slightly to MNT 48.6 billion. Net profit after tax also fell sharply to MNT 38.9 million as stated in its financial statements.

The market cap of Sharyn Gol JSC is MNT 16.2 billion. Currently, 10.1 million shares are traded on MSE. The total number of shareholders is 1016, of which six are holding more than 5 percent. Over the last year, the share price has fallen by 30 percent to MNT 1600. [ZGM]

FINANCE

World Bank: Mongolia scores 3.4 points on policy and institutional assessments

Aminaa.U
ZGM

Mongolia scored 3.4 points on the policy and institutional assessment of 2018, 0.2 points higher than the global average, reported the Bank of Mongolia (BoM).

The Policy Development Association of the World Bank Group annually conducts policy and institutional assessments. It provides a review on factors such as poverty reduction and sustainable growth, as well as policy and institutional systems and information about whether they can effectively use development aid.

Mongolia received a rating of



3.3 points in 2017 and 3.2 in 2016. As a key economic indicator, the monetary and FX policies of Mongolia were higher than the average of loan holder countries, but the budget and debt management policies were poor. In addition, structural policy indicators were assessed below the global average by 0.3 percentage points.

Structural change policy was one of the International Monetary Fund (IMF)’s Extended Fund Facility target. The review of the IMF team on the sixth phase review concluded that “The objective of the 2019 program is to continue to reduce the Government debts and resume foreign exchange reserves”. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

07.00	"Өглөө" хөтөлбөр
10.00	"Хүрээлэн" амьд ертөнцийн цуврал
14.30	Цаг үе, үзэл бодол /давталт/
17.50	Хөгжлийн замаар: "Эрүүл мэндийн үйлчилгээ"
20.00	"Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр /шууд/
21.10	"Defacto" мэтгэлцээн /шууд/
Bloomberg TV Mongolia	
07.00	"Боломжгүйг өөрчлөх төсөл" нэвтрүүлэг
11.00	"Гол сэдэв" нэвтрүүлэг
14.30	"Тэрбум долларын хэлцэл" нэвтрүүлэг
15.30	"Бизнесийн төв цэг" мэдээний хөтөлбөр
20.30	"Бүрэн тайлбар" нэвтрүүлэг
22.00	"Инновац 2050" нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ

08.07	Дэлхийн атлас нэвтрүүлэг
10.10	"Бүхнийг анагаагч хайр" СОАК 20-р анги
13.05	"Хөгжилтэй Монголдой" цэцэрлэгийн ахлах бүлэг №23
18.07	"Консуни" хүүхэлдэйн кино 48-49-р анги
20.50	"Гал тогоо" шоу нэвтрүүлэг
23.05	"Хувь тавилангийн ээдрээ" ОАК 18-р анги
МОНГОЛTV	
07.00	Өнөө өглөө
10.30	"SKY шилтгээн" СОАК 20-р анги
13.30	Chart news 56-р хэсэг
16.00	"Шивнээ" СОАК 10-р анги
18.30	"Ороод гараач" /season-2/ 11-р хэсэг
19.00	"Оргил цаг" мэдээллийн хөтөлбөр

ЗУРХАЙ



Билгийн тооллын 10
Зуны дунд цагаан морь сарын есөн улаан мэнгэтэй цагаан луу өдөр
Үс засуулбал: Эрч хүч ихэснэ
Наран ургах, шингэх: 04.53-20.47 цаг
Барилдлага: Үл зохилдох
Шүтэн барилдлага: Хуран үйлдэхүй
Суудал: Гал

Аргын тооллын зургадугаар сарын 12, Буд гараг. Билгийн тооллын 10, Тэргүүн дагуул одтой, цагаан луу өдөр.
Өдрийн наран 04.53 цагт мандан, 20.47 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхтгох, хөгжмийн ээмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, эрдэнийг гадагш өгөхөд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч ихэснэ.



IBIZA MUSIC FESTIVAL 2019 хөгжмийн фестиваль
Хаана: Монгол шилтгээн
Хэзээ: 2019.06.21-нд
Тасалбарын үнэ: ₮30-50 мянга



Б.Шарав "Чингис хаан" дуурь
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.06.29-нд
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга



"Нутаг минь хүлэг минь" концерт
Хаана: ASEM Ger
Хэзээ: 2019.06.22-23-нд
Тасалбарын үнэ: ₮40 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР



100 жилийн эморол

1919 онд хувьсгалын эсрэг тэмцэж явсан нэгэн залуу нууц захиа хүргэх замдаа буудуулж амь үрэгдэнэ. Гэвч тэр хайртай эмэгтэйдээ гомдоосны улмаас дахин амилж, насаараа хөгшрөхгүй, үхэхгүй байх хараал

хүрчээ. Ингээд 100 жил амьдарсан тэрбээр 2019 онд шинэ хайр дурлалтайгаа учирч, өөр шигээ адил зовлонтой найзтай болж авснаар шинэ адал явдал эхэлнэ. Найруулагч Ц.Амартүвшингийн бүтээл "100 жилийн эморол"

инээдмийн уран сайхны кино өнгөрсөн сарын сүүлээс кино театруудын дэлгэцнээ гарч эхэлсэн. Киноны гол дүрүүдэд О.Тэмүүжин, Б.Жамъяандорж, Ч.Очгэрэл, Ж.Мөнхсайхан, Б.Чинсанаа нар тогложээ. [ЗГМ]

ЦАГ АГААР

УЛААНБААТАР




ФОТО АГШИН



Ажлын дараа...

Ж.Гэрэлчулуун / ЗГМӨ

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1			2		3	4		5
6		7		8		9		10
11								
12			13		14	15		
16					17			

БОСООГООР:

- МУ-ын ХХ зууны манлай арслан
- Хангалуун, цатгалан
- Газраас өргөгдсөн

өндөрлөг

- 1960 оны аравдугаар сарын 2-нд амь үрэгдсэн, ардчилсан үзэлтэн, улстөрч

хөндлөнгөөр:

- Хөвсгөл аймгийн төв
- Лалын шашны нэгэн хүчтэй

- урсгал
- Гуу судар
- Монгол кино
- "Анхны..."
- МУ-ын ерөнхий сайд асан, хутагт
- Асар их баялаг

- бүхий орд
- Цогт тайж киноны найруулагч, ЗХУ-ын ардын жүжигчин
- Адууны гоёмсог явдал
- Хүчилтөрөгч

Өмнөх дугаарын хариу / 06.11

М	И	К	Е	Л	А	Н	Ж	Е	Л	О
Е		А			Т		В			И
С	Н	З	Г	О	Л	А		А	Л	Д
С			О	С	А	Я				О
И	Р		Т		Н		А	Б		В
У	Р	А	Н		А	Д	А	Я	Н	

ЗГМ: СУДОКУ

	4	3				9
		7	6		5	
		2	4		5	1
1		3				2
8				4		
2				6	9	8
	3	1	7			
	9			2		5
	2				1	9
					4	

9	4	8	6	5	2	1	3	7
7	1	6	8	4	3	9	5	2
3	2	5	1	9	7	6	8	4
1	6	3	7	8	9	2	4	5
2	5	7	3	1	4	8	9	6
4	8	9	5	2	6	3	7	1
6	7	2	4	3	8	5	1	9
5	3	4	9	6	1	7	2	8
8	9	1	2	7	5	4	6	3

(Амрах дугаарын хариу)

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ		
МОСКВА - УБ	23.55	06.50
УБ - САЙНШАНД	21.08	06.48
САЙНШАНД - УБ	20.10	06.45
УБ - ЗАМЫН ҮҮД	17.15	07.20
ЗАМЫН ҮҮД - УБ	18.05	08.45
УБ - СҮХБААТАР	10.45	19.41
СҮХБААТАР - УБ	07.15	16.30
УБ - ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ - УБ	18.35	06.00

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ		
УБ - БЭЭЖИН	06.10	08.25
БЭЭЖИН - УБ	09.30	12.00
УБ - ФРАНКФУРТ	09.40	13.00
ФРАНКФУРТ - УБ	14.30	05.20
УБ - СӨҮЛ	08.40	12.50
СӨҮЛ - УБ	14.20	17.00
УБ - ШАНХАЙ	13.15	16.50
ШАНХАЙ - УБ	17.50	21.40
УБ - ТОКИО	07.45	13.40
ТОКИО - УБ	14.40	19.15
УБ - ЭРХҮҮ	05.55	07.00
ЭРХҮҮ - УБ	08.00	09.10

ЭДИЙН ЗАСАГ

Хятад худалдааны дайнтай тулгарсан ч алтны нөөцөө нэмэгдүүлэв

Хятад улс зургаан сар дараалан алт худалдан авалтаа нэмэгдүүлж, хөрөнгийн нөөцөө төрөлжүүлж байна.

> 10

Төмрийн хүдрийн үнэ таван жилийн дээд түвшинд хүрлээ

Японы JFE Holdings төмрийн хүдрийн үнийн өсөлтийг хэрэглэгчдэд үүрүүлэх чиглэл барихаа анхааруулав.

> 10

Жиргээгээрээ зах зээлийг хөдөлгөдөг Хятадын редактор

Хөрөнгө оруулагчид Хятадын хариу алхмын талаар мэдээлэл авахын тулд твиттерийг ажиглаж байна.

> 10


Цэцэглэж буй шүлтлэг усны наймаа

Одоо ч савласан усны аварга зах зээлд багахан хувь эзэлж буй шүлтлэг усны үйлдвэрлэл АНУ-д дөрөвдүгээр сараар төгссөн бүтэн жилд даруй 36 хувиар өсөж 270 сая ам.доллар болсныг статистик судалгааны SPINS компани тооцоолжээ.

Шүлтлэг усны наймаа мөнгөний эх булаг гэдэг нь тодорхой. Харин энэхүү онцгой ус маань хэрэг дээрээ үнэхээр онцгой эсэх нь тодорхойгүй.

Зарчмын хувьд шүлтлэг ус гэдэг нь ердөө л электролит үүсгэх давс, pH түвшнийг нь ихэсгэхийн тулд хүнсний сода нэмсэн цэвэршүүлсэн ус юм. Шинжлэх ухааны талаас тайлбарлагчид шүлтлэг усанд эргэлзэнгүй ханддаг бол ийм усыг дэмжигчид бие махбодын хучил, шүлтийн тэнцвэр бариулж, крантны уснаас илүү цангаа тайлдаг хэмээн мэтгэдэг. Гоожуурын усны pH нь саармаг буюу долоо орчимд хэлбэлздэг бол АНУ-д борлуулалтаараа тэргүүлж буй Essentia шүлтлэг усных доод тал нь 9.5 хэмээн үйлдвэрлэгч нь тайлбарлаж байна.

Хэрэглэгчид шүлтлэг усанд өндөр үнэ төлцгөөж, тамирчид болон олон нийтэд алдартай хүмүүсийн нэрээр компаниуд сурталчилгаа өрнүүлдэг болов. Америк хөл бөмбөгийн од Том Брэди хатуу дэг барьж өглөө бүр хагас литр шүлтлэг ус ууж байна. Эрүүл мэнддээ санаа тавигчдын хүрээнд нөлөөтэй, жүжигчин Гвинет Пэлтроугийн Гоор брэнд мөн л шүлтлэг ус үйлдвэрлэгч Flow брэндтэй түншилж байгаа. Flow нь лонхолсон усаа “байгальд



Имплант суулгаж ой санамжаа сайжруулах нь



АНУ-ын Батлан Хамгаалах Яамны харьяа DARPA агентлаг уураг тархи нь гэмтсэн хүмүүсийн ой санамжийг сэргээх төхөөрөмж хөгжүүлэхэд 77 сая ам.долларын хөрөнгө оруулаад байна.

Кэролайн Уинтер

Миннесота муж улсын Мэйо эмнэлэгт (Mayo Clinic) авсан эхний видео дүрс бичлэгт эмнэлгийн орон дээр суугаа, толгой нь боолттой өвчтөн харагдаж байна. “Халим”, “нүх”, “амьтны хүрээлэн” гэх мэт 12 үг цээжлэх гэж оролдож буй өвчтөн ердөө гурвыг нь л нэрлэж дөнгөлөө. Хэчнээн чармайгаад өвчтөн бусдыг нь санаж чадалгүй бууж өгөв. Хоёр дахь видео бичлэгт нөгөө өвчтөн маань 12 үгийг торох юмгүй давтаж байх юм. “Та бүгдийг нь санаж чадаад байна!” хэмээн судлаачид магтацгаалаа. Энэ удаад өвчтөний тархинд мэс заслын аргаар суулгасан хиймэл санах ой тус болжээ.

АНУ-ын Батлан Хамгаалах Яамны харьяа тусгай судалгааны

DARPA (Defense Advanced Research Projects Agency) агентлаг уураг тархи нь гэмтсэн хүмүүсийн ой санамжийг сэргээх төхөөрөмж хөгжүүлэхэд 77 сая ам.долларын хөрөнгө оруулаад байна. Тус агентлаг хүмүүн-өвчтөнүүдэд явуулсан хоёр ч хэсэг судалгааны тайлангаа өнгөрсөн онд нийтэлсэн.

Мэйо эмнэлэгт ашигласан төхөөрөмжийг Пенсильванийн их сургуулийн сэтгэл судлалын ухааны профессор Майкл Каана анагаах ухааны технологийн Medtronic Plc компанитай хамтран бүтээсэн юм. Зүүн тархины бор гадаргатай холбогддог уг төхөөрөмж нь тархины цахилгаан идэвхийг хэмжин санахуй үүсэх явцыг тодорхойлж өгдөг. “Цаг уур

судлаачид гадаа хэмжих багаж байрлуулж агаарын чийгшил, салхины хурд, температурыг тооцоолдогтой л адилхан. Тархинд сенсор төхөөрөмж байрлуулж цахилгаан дохиог нь барьж авч буй хэрэг” хэмээн Каана тайлбарлав. Тархины ажиллагаа зохих хэмжээнээс дутуу байх аваас уг төхөөрөмж өвчтөнд өөрт нь үл анзаарагдах маш өчүүхэн цахилгаан лугшаа дамжуулах аргаар мэдрэлийн дохиог “өсгөж” ой санахуй бүрдэхэд нь тус болдог. Хоёр тусдаа явуулсан урьдчилсан туршилтын дүнгээс үзвэл уг төхөөрөмж ой санамжийг 15-аас 18 хувь сайжруулж чадаж байна.


Хоёр дахь бүлэг туршилтыг Умард Каролина муж улсын Уэйк Форест баптист анагаахын

төвийн баг Өмнөд Каролина муж улсын их сургуулийн эрдэмтдийн туслалцаатайгаар илүү нарийн түвшинд явуулсан юм. Жилийн өмнө явуулсан судалгааны тайлангаас үзвэл, уг судалгаанд хамрагдсан өвчтнүүдийн ой санамж 37 хувиар дээрджээ. “Түлхүүр хаана байгаа билээ?”, “Машинаа хаана орхилоо?”, “Эмээ уусан билүү?” гэх мэт амьдралын өдөр тутмын асуултад хариулах чадвараар нь үнэлж шалгаснаа 2018 оны судалгааг удирдсан Роберт Хэмпсон тайлбарласан юм.

Ой санамж үүсгэхийн тулд уураг тархины хэд хэдэн төрлийн нейрон код гэж нэрлэж болох мэдээллийг тун өвөрмөц маягаар дамжуулдаг. “Энэхүү код нь ой санамж болгонд, хувь хүн бүрд өвөрмөц” хэмээн доктор Хэмпсон өгүүлэв. Эрдэмтэд хүний уураг тархинд ой санамж үүсэхэд гол үүрэгтэй хилпокамп буюу “далайн морь” гэгддэг хэсгийн нейроны ажиллагааг судалж зөв, буруу санахуйн мэдээлэл үүсгэдэг механизмыг өвчтөн тус бүрд тодорхойлсон байна. Уг судалгаандаа тулгуурлан тархи алдаа гаргах тохиолдолд кодыг нь засаж өгөх механизм үүсгэжээ.

Судалгааны цаашдын шатанд төхөөрөмжийн овор хэмжээг багасгаж, зах зээлд гаргахын тулд АНУ-ын Хүнс, Эмийн Бүтээгдэхүүний Захиргаанаас (US FDA) зөвшөөрөл авах юм. Nia Therapeutics Inc хэмээх старт-ап доктор Кааны төхөөрөмжийг арилжааны хэрэглээнд нэвтрүүлэхээр ажлаа хэдийн эхлээд байна.

Банкаа дүүргэхээ азна, шатахууны үнэ буух гэж байна




Жеффри Бэйр

Машиндаа шатахуун хийлгүй долоохон хоног тэсчихвэл АНУ даяар бензиний үнэ галлон (ойролцоогоор 3.8 литр) тутамд 16 центээр буух гэж байна. Ford Expedition унадаг хүн нэг удаа саваа дүүргэхэд 5.36 ам.доллар хэмнэнэ гэсэн үг.

АНУ-д сүүлийн хэдэн долоо хоногийн турш тогтвортой буурч ирсэн шатахууны үнэ зуны аяллын цаг эхэлж, газрын тосны үнэ унасантай уялдан цаашдаа ч хямдрах төлөвтэй байна. Газрын тосны нэрэх үйлдвэрүүд ихтэй Хьюстон орчимд галлон бензин хоёр доллар орчим болсныг GasBuddy.com-ын статистикаас үзэж болно.

Америкийн Автомашины

Холбооны (AAA) тайланд дурдсанаар, жилийн өмнөх өдий үед АНУ-д нэг галлон регуляр бензин 2.92 ам.доллар байжээ. Нью-Йоркийн биржид газрын тосны үнэ 18 хувиар унасантай уялдан өдгөө буюу хаврын үнэ 2.75 ам.доллар байгаа юм. АНУ-д замд гарах жолооч нарын тоо ихэсдэг хаврын улиралд шатахууны үнэ үнэмлэхүй өсдөг. “Өнгөрсөн долоо хоногт үнэ долоон центээр буусан. Энэ долоо хоногт дахиад бууж таарах учраас банкаа дүүргэх гэж яарах хэрэггүй гэж зөвлөх байна” хэмээн GasBuddy.com-ын шинжээч Патрик ДеХаан утсаар тайлбарлав. “Энэ долоо хоногт галлон бензин 2.60, аягүй бол 2.59 ч болж магадгүй!”



Шиг G20-ийн үеэр өөртэй нь уулзахгүй бол тарифаа өсгөнө гэж Трамп сүрдүүлэв

Маргарет Тэйли

Японд чуулах G20-ийн чуулганы үеэр БНХАУ-ын Дарга Ши Жиньпинийг өөртэй нь уулзахгүй байх аваас Хятадад оноох тарифаа өсгөхөөр АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп сүрдүүлээ. Хятадад нэмж оноох тарифаа 25 хувь “эсвэл бүр 25 хувиас ч ихээр” тогтооно хэмээн Трамп даваа гарагт Цагаан ордноо сэтгүүлчдэд мэдэгдсэн юм. Чуулганы үеэр Хятадын удирдагч өөртэй нь уулзахгүй бол тариф оноохоо Дональд Трамп урьд нь мөн CNBC-д өгүүлж байв.

Да Винчигийн бүтээлийг хунтайжийн онгоцонд хадгалж байна



Катя Казакина

Леонардо Да Винчигийн шилдэг бүтээл болох Salvator Mundi 2017 онд 450 сая ам.доллараар зарагдсан. Түүнээс хойш байршил нь нууц байсан уг уран зураг санаанд оромгүй газарт байгааг Artnet.com мэдээлэв. Саудын Арабын угсаа залгамжлах хунтайж Мохамед Бин Салманы эзэмшдэг Serena хэмээх супер яхт онгоцноо уг зургийг хадгалж байгааг интернэт сайт тайлбарлаж байна. Угсаа залгамжлах хунтайжийн нэрийн өмнөөс 500 жилийн түүхтэй өөр нэг сод бүтээлийг Christies-ын үнэ хаялцуулах худалдаанаас худалдаж авснаа Саудын “ердийн” ханхүү урьд нь New York Times-д өгүүлсэн юм.

YouTube-ын гүйцэтгэх захирал LGBTQ нараас уучлал хүслээ



Герит Де Винк

Хошин жүжигчин, тайлбарлагч Стивен Краудерын бэлгийн цөөнхийг ялгаварлан гадуурхсан шог яриатай холбогдуулан YouTube-ийн гүйцэтгэх захирал Сьюзан Войчички LGBTQ нараас уучлал хүслээ. Видео контентын аварга өнгөрсөн долоо хоногт YouTube дэх Краудерын сургийг түр зогсоосон юм. Стивен Краудерын контент YouTube-ын баримталдаг бодлогыг зөрчөөгүй боловч нийгмийн зарим хэсэгт доромжлол болсонд харамсаж буйгаа тэрбээр илэрхийлэв.

Эдийн засаг

Хятад худалдааны дайнтай тулгарсан ч алтны нөөцөө нэмэгдүүлэв

Ранжита Пакиам

АНУ-тай худалдааны зөрчил үргэлжлэх завсар Хятад улс зургаан сар дараалан алт худалдан авалтаа нэмэгдүүлж, хөрөнгийн нөөцөө төрөлжүүлж байна. Хятадын Ардын банкны алтны нөөц тавдугаар сард 61.10 сая унц байсан бол одоо 61.61 саяд хүрээд байгааг даваа гарагт мэдээлэв. Тонны хэмжээгээр авч үзвэл 15.86 тонноор өссөн хэрэг бөгөөд он гарсаар тус улсын алтны нөөц нийт 58 тонноор нэмэгджээ. Argonaut Securities фирмийн шинжээч Хелен Лаугийн хэлснээр энэ нь Хятадын Засгийн газар ам.долларын хадгаламжаас холдож, нөөц төрөлжүүлэх бодлого барьж буйн илрэл юм. Хуримтлал ийнхүү өсөх явцад Хятад 2019 онд 150 тонн алт худалдан авах төлөвтэй байгаа нь алтны үнийг дээшлүүлэв. Шар металлын үйлдвэрлэл ба хэрэглээгээр дэлхийд тэргүүлдэг Хятад улс АНУ-ын зүгээс тарифын



арга хэмжээтэй тулгарсан учир дотоод эдийн засгийн өсөлт нь саарч байгаа. Ардын банкны сүүлийн мэдээнээс үзвэл Хятад 2016 оны сүүлээс өнгөрсөн арванхоёрдугаар сар хүртэл үргэлжилсэн тогтмол хэмжээгээр худалдан авах бодлогоос татгалзаж, алтаа нөөцөө түргэн арвижуулах дохио өгчээ.

TD Securities фирмийн таваарын стратегийн хэлтсийн тэргүүн Барт Мелек “Худалданы

зөрчил хийгээд технологийн хүйтэн дайн дэгдэх шинжтэй байгаа үед ам.доллараас холдож, нөөцөө төрөлжүүлэх алхам хийгдэж байна. Алт эзэмшигчээсээ өөр хэнд ч харьяалагдаагүйг санах ёстой” хэмээн тайлбарлав. Сүүлийн гурван долоо хоногт алтан гулдмайн үнэ өсөж, 2018 оны дөрөвдүгээр сарын дээд түвшин дээр ирлээ. Холбооны нөөц бодлогын хүүгээ танах төлөв

ажиглагдаж буй нь алт өсөх бас нэг шалтгаан болжээ.

Алтны үнэ тавдугаар сард 1.7 хувь дээшилж, даваа гарагийн байдлаар унц нь 1329.60 ам.долларын үнэтэй байв. Хятад улс алтны худалдан авалтаа нэмэлгүй нэлээд удсан. Ардын банк 2015 оны дундуур алтны нөөцөө 57 хувиар өсгөж, 53.3 тоннд



хүргэхээ зарласан зургаан жилд анх удаа авсан арга хэмжээ байв. Шинэ тутам зах зээлүүдийн төв банкууд алтны нөөцөө арвижуулж байгаа үед Хятадын Ардын банк мөн адил алхам хийж эхэллээ. Дэлхийн алтны зөвлөлийн тооцоогоор Хятадын оны эхний улирлын алт худалдан авалт зургаан жилийн дээд түвшинд байжээ.

Audi цахилгаан машинаа АНУ-ын зах зээлээс татжээ



Дана Халл

Volkswagen компанийн тансаг зэрэглэлийн машин үйлдвэрлэдэг Audi салбар батарей шатах эрсдэлийн улмаас анхны бүрэн цахилгаан машинаа Америкийн зах зээлээс сайн дураар татаж эхлэв. “Энд зарагдсан 540 орчим E-Tron хэмээх SUV төрлийн машиныг батарейд нь утсаар дамжин чийг орж болзошгүй учир татаж байна” хэмээн компанийн

хэвлэлийн төлөөлөгч Марк Данке хэлсэн байна.

Гэхдээ уг загварын 1644 машинд тавьсан батарейн доголдлын улмаас гал гарсан буюу жолооч гэмтсэн тохиолдол бүртгэгдээгүй аж. E-Tron дөрөвдүгээр сараас АНУ-ын зах зээлд худалдагдсан бөгөөд уламжлалт машин үйлдвэрлэгчид Tesla-тай өрсөлдөж, бүрэн цахилгаан машин бүтээхийг эрмэлзэж буй

үед гарч ирсэн Audi-гийн анхны бүрэн цахилгаан загвар юм. Цахилгаан машинууд энгийн бензин машинаас илүүтэй шатах, осолд орох эрсдэлтэй гэх үзэл бодол цаашдаа явуургүй гэж Үндэсний замын аюулгүй байдлын захиргаа мэдэгдэв.

Литий-ион батарейн технологи улам бүр сайжирч байгаа ч аюулгүйн системийн дизайн дээр нэгдсэн шийдэлд хүрч чадаагүй байгаа юм. Au-

di-гийн төлөөлөгчийн хэлснээр батарейд чийг орсны улмаас машин шатсан тохиолдол дэлхийд таван удаа бүртгэгдсэн байна. Холбооны аюулгүйн албаныхан сануулга өгөхөөс өмнө E-Tron-ыг буцаан татаж, наймдугаар сар гэхэд доголдлыг арилгана гэж үйлдвэрлэгч амлажээ.

Компанийн төлөөлөгч хэлэхдээ “Бид хангалттай анхааруулга өгсөн бөгөөд дэлхийд ийм осол гараагүй байгаа” гэж мэдэгджээ. Гэхдээ Audi компани E-Tron машин эзэмшигчдэд засварын хугацаанд түрээсийн машин болон бензиний үнэд 800 ам.доллар олгосон байна. Энэ нь засварын хугацааны даатгалын нөхвөр бөгөөд шаардлагатай бол түрээсийн машинд үнэгүй засвар хийж өгөх аж. Гэхдээ засварт хамрагдахгүй цахилгаан машинууд худалдаанд байгаа гэж компанийн төлөөлөгч хэллээ.

Жиргээгээрээ зах зээлийг хөдөлгөдөг Хятадын редактор



Bloomberg News

Хөрөнгө оруулагчид Хятадын ил тод бус Засгийн газар худалдааны дайныг хэрхэн явуулж буй талаар мэдээлэл авахын тулд санаанд оромгүй эх сурвалжийг анхаарч байна. Тэр нь хатуу байр суурьтай төрийн хэвлэл юм. Саяхан Global Times сонины ерөнхий редактор Ху Сижин Хятадын хэд хэдэн алхмыг нарийн таамаглаж твиттертээ бичсэний дотор Америкийн Fedex компани Huawei-н хүргэлтийг гүйцэтгэхээ зогсоох, АНУ-ын их сургуулиудад сурдаг Хятадын оюутнуудад Засгийн газраас анхааруулга өгөх зэрэг арга хэмжээ багтсан байна.

Түүний нэг жиргээний дараа Boeing корпорацийн хувьцааны үнэ дөрвөн сарын доод түвшин рүүгээ унаж байв. Ноён Ху Bloomberg телевизэд өгсөн ярилцлагадаа “Би өөрийн ажлын шаардлагаар зарим мэдээллийг авдаг. Гэхдээ хэн ч түүнийг ил болгох зөвшөөрөл өгдөггүй. Хятадын албаныхан ийм мэдээг надад санаатайгаар өгдөг эсэхийг би мэдэхгүй. Бидний хооронд чимээгүй зөвшилцөл үйлчилдэг” гэсэн юм. Дэлхийн хоёр дахь эдийн засаг ноён Хуг бодлогын гол мэдээлэгчээ болгон ашиглаж байгаа нь Ерөнхийлөгч Трамп ба Ши Жиньпин нарын олон нийтийн харилцааны стратегийн ялгааг тодорхой харуулж байна.

Трамп тарифын тоглоомоо твиттерээр гэнэт зарладаг бол ноён Ши албаныхан, сонин хэвлэлээр дамжуулан ёгт үгээр санаагаа илэрхийлдэг. Ийм хүчин чармайлтад төрийн агентлагууд болон үзэл суртлын байгууллагуудад маш эмзэг нарийн ханддаг сэдвээр тайлбар

өгдөг цөөн тооны Ху шиг хүмүүс хэрэгтэй. Твиттерт түүнийг дагагчдын тоо сүүлийн сард хоёр дахин өсөж, 48400 болжээ. Bear Traps Report хөрөнгө оруулалтын мэдээний сониныг үндэслэгч Ларри МкДоналд түүнийг “Трампын твиттерийн Хятадын коммунист хувилбар” гэж нэрлэжээ.

Тэрбээр цааш нь “Миний мэдэх олон хөрөнгө оруулагч, менежерүүд Хугийн твиттерийг ажигладаг. Түүгээр худалдааны дайн ба бусад асуудлаар Хятадын байр суурийн тухай гол мэдээлэл олж авах боломжтой. Хугийн твиттер бол Хятадын тэмцлийн нэг арга хэлбэр. Коммунист намын хэлэлцээний нэг тактик юм” хэмээн тайлбарлав. Англи хэл дээр гардаг Global Times сонины нийтлэлийн бодлого голдуу өрнөдийнхний бичдөг Хятадын тухай өгүүлэл, бичлэгүүдийг сөрөх чиглэлтэй байдаг.


Ноён Ху 2005 оноос хойш тус сониныг удирдаж буй агаад 2014 онд Хятадад АНУ-ын сайтыг хориглосны дараахнаас жиргээнд нэгджээ. Global Times-ын хэвлэлээр дамжуулан Хугийн жиргээ Хятадын хүний эрхийн байдлыг хамгаалж, улс орны хөгжлийг магтсан үгээр дүүрэн. Тэрбээр Bloomberg-д ярилцлага өгөх үедээ худалдааны дайныг үл харгалзан улсын эдийн засаг өснө гээд “Хятад улс алдагдлыг гэсэн гарч чадна. Цаг хугацаа бидний талд байна” хэмээв. Гэхдээ Хятадын талаас авах хариу арга хэмжээний тухай түүний жиргээ хамгийн сонирхолтой юм. Тэрбээр сүүлд Трампын тулган шаардлагыг шийдвэрлэх боломж тэгтэй тэнцүү гэсэн байна.

Төмрийн хүдрийн үнэ таван жилийн дээд түвшинд хүрлээ

Масуми Суга

Азийн томоохон үйлдвэрлэгчдийн нэг JFE Holdings өнгөрсөн сард таван жилийн дээд түвшиндээ хүрсэн төмрийн хүдрийн үнийг хэрэглэгчдэд үүрүүлж, ашгаа хадгалах чиглэл барихаа анхааруулав. Тус компанийн санхүүгийн захирал Масашин Терахата “Төмрийн хүдрийн нийлүүлэлт тасалдах шууд эрсдэл алга. Хангалт дутагдсанаас гангийн үйлдвэрлэлд саатал гарахгүй байна” гэжээ. Эднийх ирэх гуравдугаар сар хүртэл үргэлжлэх санхүүгийн жилд хүдрийн үнэ ба бусад зардлын өсөлтийг бэлэн бүтээгдэхүүний үнэд шингээхээр тооцсон байна.

Тавдугаар сард Бразилын Vale SA компанийн далан нурж, дэлхий даяар нийлүүлэлт хомсодсоноос шалтгаалан 2014 оноос хойш тасралтгүй дээшилсэн төмрийн хүдрийн үнэ таван жилийн дээд цэгтээ хүрсэн. Түүнээс хойш үнийн дарамт арай суларч, тонн нь 100 ам.доллар дээр ирсэн боловч Хятад гангийн үйлдвэрлэл нэмэгдэж, хүдрийн нөөц багассанаас үнийг дээш түлхэж болзошгүй байна. Терахатагийн хэлснээр JFE Holdings нэмэлт материал болон түгээлтэд илүү



үнэ төлж байгаа аж.

Тэрбээр тус компани нөөцөө нэмэхийн тулд хоёрдугаар сард Хятадын шинэ жилийн үеэр спот гэрээ байгуулж, нэлээн хэмжээний хүдэр худалдан

авсныг мэдээлэв. Vale SA эднийд гэрээлсэн хүдрээ нийлүүлэх үүрэг хүлээсэн авч JFE Бразилын нийлүүлэлт тасалдахаас бол-гоомжлон Австралиас нэмж хүдэр авах боломж хайж байгаа аж. Тус

Эдийн засаг

Хятадын импорт буурч байгаа нь бидэнд болгоомжлох дохио өгч байна

Худалдааны дайн цаашид муугаар эргэвэл эрчим хүчний хэрэглээ, импортын худалдан авалтаа ч мөн бууруулах магадлалтай.



С.Батсайхан / ЗГМ©

Манай гол асуудал бол инфляц биш гадаад худалдаан дээр гарч болох өөрчлөлт

Т.Элиса

Эдийн засагч Н.Энхбаяртай ярилцлаа. Тэрбээр Америк, Хятадын хооронд өрнөж буй худалдааны дайн манай нүүрсний экспортод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг сануулсан юм.

-Татварын багц хууль сайн хууль болж чадсан уу. Ерөнхийлөгчийн хоригийн талаар ямар бодолтой байна вэ?

-Ерөнхийлөгчийн тавьсан хоригт гадаадын зарим компанид давуу тал олгосон байж болзошгүй гэсэн үндэслэл дурдагдсан байна лээ. УИХ хоригийг хүлээж аваад эргэлзээтэй зүйл заалтуудыг дахин харах бололцоо гарлаа гэж найдаж байна. Татварын багц хуулийн өөрчлөлт ЖДҮ-ийн бизнесийг дэмжих, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа, хэт өндөр зардалтай ААН-үүдэд боломж олгох заалт орж байгаа.

-Ойрын хугацаанд мөнгөний бодлогын зөвлөл хуралдаж, шийдвэрээ гаргах байх гэсэн хүлээлт байна. Мөнгөний бодлогын хүүнд өөрчлөлт оруулах болов уу?

-Одоогоор Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд

нааштай байгаа. Тиймээс мөнгөний бодлогын хүүнд өөрчлөлт оруулах үндэслэл байхгүй болов уу. Төв банкны судлаачдын зүгээс болгоомжилж буй эрсдэлүүд бий. Зургадугаар сард болох дэлхийн томоохон үйл явдлуудын дараа эдгээр асуудлыг хэлэлцэх болов уу.

● **УИХ Татварын хуульд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваад эргэлзээтэй зүйл заалтуудыг дахин харах байх.**

● **Арилжааны банкууд активын чанарын үнэлгээ хийлгэсэн боловч гарсан үр дүн ОУВС-гийн итгэл үнэмшлийг төрүүлж чадахааргүй байсан.**

● **Төв банк эрсдэлээс хамгаалах хамгийн найдвартай хэрэгсэл болгож алтны худалдан авалтыг нэмэгдүүлж байгаа болов уу.**

-Дотоод үзүүлэлт талаасаа инфляцын эрсдэл бий гэж эдийн засагчид үздэг. Инфляц одоогоор ямар түвшинд байна вэ?

-Судлаачийн зүгээс харахад инфляцын эрсдэлээс болгоомжлохгүй байна. Одоогийн үнийн өсөлт бол улирлын чанартай. Харин түлш, шатахууны үнийн өсөлт гадаад хүчин зүйлийн нөлөөтэй. Богино хугацааны дэлхийн зах зээл дэх үнийн өрсөлдөөн цаашдаа ч байна. Манай гол асуудал бол инфляц биш гадаад худалдаан дээр гарч болох өөрчлөлт юм.

-Гадаад худалдаанд ямар өөрчлөлт гарна гэж болгоомжилж байна вэ?

-Гаалийн статистикийн эхний таван сарын мэдээллээр экспорт өмнөх оны мөн үеэс 370 сая ам.доллараар, импорт 130 гаруй сая ам.доллараар нэмэгдсэн үзүүлэлт гарсан. Гадаад худалдааны тэнцэл оны эхний таван сарын байдлаар 950 сая ам.долларын ашигтай гарсан. Экспортоор гаргаж байгаа нүүрсний хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс нэг сая тонноор илүү гэх мэт нааштай өөрчлөлтүүд бий. Гэхдээ манай экспортын 90 гаруй хувийг эзэлж байгаа түүхий эдийн гол худалдан авагч нэг л зах зээл байгаа. Урд хөршийн оны эхний таван сарын үзүүлэлт импортын хувьд буурсан байсан. Үүнийг бид бодлогоор бууруулсан байх гэж харж байна. Учир нь хоёр улсын хооронд өрнөж буй худалдааны дайн үүнд нөлөөлсөн. АНУ ирэх долоо хоногт 300 тэрбум ам.долларын

татвараа нэмэх асуудлыг эцэслэн зарлах гэж байна. Хэрвээ худалдааны асуудал буруугаар эргэвэл Хятадаас Америк руу гаргах экспортын хэмжээ буурна. Одооноос импортын гадаад нөлөөг бууруулж, тэнцлийн ашгаа нэмэгдүүлж байгаа нь экспорт буурсан нөхцөлд үүний нөлөөг бууруулах хэлбэрт шилжиж байгаа гэсэн үг. Хятадын импорт буурч байгаа нь бидэнд болгоомжлох дохио өгч байна.

-ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн зургадугаар шатны үнэлгээ нэлээд хойшилж байна. Энэ жил орж ирэх санхүүжилтийн хэмжээ 840 сая ам.доллар гэж тооцож байгаа. Өнгөрсөн жил 400 сая ам.доллар хүрээд зогссон эрсдэл бий. Энэ оны тухайд эрсдэл үүсэх болов уу?

-ОУВС-гийн ажлын хэсэг сүүлд хийсэн хурлаараа үнэлгээ хойшилсон талаар тодорхой тайлбарыг өгсөн. Бидний зүгээс бидсэн макро үзүүлэлтүүдээ биелүүлээд явж байгаа. Гэхдээ арилжааны банкууд активын чанарын үнэлгээ хийлгэсэн боловч гарсан үр дүн ОУВС-гийн итгэл үнэмшлийг төрүүлж чадахааргүй байсан. Зарим арилжааны банкны активын чанарын үзүүлэлтийн дүнг нягталж үзэх шаардлагатай гэсэн. Дараагийн ажлын хэсэг зохих үнэлгээг бодитоор гаргах байх гэж найдаж байна.

-Энэ онд хөтөлбөрийн хүрээнд орж ирэх санхүүжилтийн хэмжээ тасрах эрсдэл байгаа юу?

-Гадна талаасаа бид итгэл

найдвар дүүрэн байгаа. Хамгийн гол нь бид хүлээсэн үүргээ биелүүлж чадах уу гэдэг асуудал л бий.

-Нэгдүгээр улирлын байдлаар алт худалдан авалтын хэмжээ сүүлийн зургаан жилийн үзүүлэлтээс хамгийн дээд цэгтээ хүрсэн гэж Дэлхийн алтны зөвлөл мэдээлсэн байгаа. Үүнээс харахад эрсдэл их байна гэж ойлгож болох уу?

-Америк, Хятадын худалдааны дайнаас сар болгон шинэ мэдээлэл гарч байна. Зургаан сарын эхээр Хятадын талаас худалдааны дайны талаар баримталж буй байр сууриа албан ёсоор илэрхийлсэн. Төв банк энэ мэт эрсдэлээс хамгаалах хамгийн найдвартай хэрэгсэл болгож алтны худалдан авалтыг нэмэгдүүлж байгаа болов уу.

Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд нааштай байна

-Энэ удаагийн Их 20-ийн уулзалтаар ямар нэгэн ахиц гарах болов уу?

-Өнгөрсөн 2018 онд АНУ-ын төлөөлөгчийн газраас Хятадын худалдаа, оюуны өмчийн талаар баримталж буй бодлогын талаар тайлан гаргасан. Энэ тайланд үндэслэлд худалдааны татвар тогтоох асуудлууд эхэлсэн. Америк дөрвөн үе шаттай нийт 540 тэрбум ам.долларын татварын тариф тогтоосон. Их 20-ийн орнууд технологийн компаниудад зориулсан татварын нэгдсэн систем байгуулахаар төлөвлөж байгаа. Хэрэв Хятад, Америкийн худалдааны маргаан 2020 он хүртэл үргэлжилбэл дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлөх тул нааштай шийдэхийг уриалж буй. Манай улсад ч гадаад худалдаагаар дамжин нөлөөлнө. Зарим нэр төрлийн барааны импорт буураад байна. Цаашдаа маргаан муугаар эргэвэл эрчим хүчний хэрэглээ, импортын худалдан авалтаа ч мөн бууруулах магадлалтай. Нүүрсний экспортын хэмжээ буурвал бидэнд том хохирол учирна. Уул уурхайн хөрөнгө оруулалтад нааштай бодлогоор хандахгүй бол уул уурхайг нөхөх бусад салбарын экспортын орлого хангалттай бус. Бусад салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалт эдийн засгийг тогтвортой байлгах хэмжээнд хүрэхгүй.

ЗГМ ТОВЧХОН

» **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**
Монголын хөрөнгийн биржийн мягмар гарагийн арилжаагаар 22 компанийн 89,526,624 төгрөгийн үнийн дүн бүхий 175,712 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр найман компанийн хувьцааны ханш өсч, 12 компанийн ханш буурсан бол хоёр компанийн хувьцааны ханш тогтвортой байв.

» ИМПОРТ

23

Хувь. Тавдугаар сард БНХАУ-ын нүүрсний импорт өмнөх сараас 23 хувиар өссөн байна.

» ҮНЭЛГЭЭ

11

Хувь. 5500 ккал илчтэй нүүрсний үнэлгээ сүүлийн нэг жилд 11 хувиар буурч, тонн нь 590 юань болжээ.

» ХӨДӨӨ АЖ АХУЙ

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл дэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо зохион байгууллаа.

» ҮНЭ ХАНШ

62

Ам.доллар. Өнгөрсөн сарын эхээр 71 ам.доллар байсан брент маркийн газрын тосны үнэ 62 ам.доллар болж буурлаа.

» ХЭЛЭЛЦЭЭР

Их Британи БНСУ-тай Брекситийн дараах чөлөөт худалдааны хэлэлцээр байгууллаа. Хэлэлцээрийн хүрээнд БНСУ-аас Их Британид нийлүүлдэг автомашин, авто сэлбэг болон Их Британиас БНСУ-д экспортолдог газрын тос, автомашин, виски хамаарах аж.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,652.13
Евро	2,986.43
Японы иен	24.45
ОХУ-ын рубль	40.78
БНХАУ-ын юань	383.83
БНСУ-ын вон	2.24

САНХҮҮЖИЛТ

Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн зээлийн эрэлт өндөр байна

Э.Ууганбилэг
ЗГМ

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн урт хугацаатай, хөнгөлөлттэй олгох зээлийн хүсэлтийг хүлээн авч дууссаныг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас мэдээллээ. Төсөл хүлээн авах ажиллагааг 21 аймаг, Улаанбаатар хотын гурван цэгт явуулж, нийт 2752 иргэн, аж ахуйн нэгжээс 487 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт иржээ. Тодруулбал, орон нутгаас 20-200 сая төгрөгийн хооронд зээл авах хүсэлтэй 1341 иргэн, ААН-үүдээс нийт 106 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирсэн. Харин Улаанбаатар хотоос 1411 иргэн, ААН-ийн 381 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтийг бүртгэсэн байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хэмжээ өмнөх жилүүдийнхээс хоёр дахин буурч 47 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь зээлийн хүсэлтийн дүнтэй харьцуулахад 10.3 дахин бага



С.Батсайхан / ЗГМ©

дүн юм.Өөрөөр хэлбэл, жижиг дунд үйлвэрийг хөгжүүлэх эрэлт хэрэгцээ өндөр байна гэж салбарын яамнаас мэдээллээ. Түүнчлэн өнгөрсөн баасан гарагт хөнгөлөлттэй зээлийг дамжуулж олгох банкууд шалгарсан байна. ХААН, Хас, Төрийн банкаар төслийн зээлийн олгоно. ХХААХҮЯ эдгээр банктай хэлэлцээ хийж зээлийг дамжуулан олгох журам, зээлийн

үйлчилгээний зардал, хүүгийн зардлаар хэлэлцээ хийх аж.

Эхний шатны төсөлд тавигдах шаардлага, иж бүрдлийн шаардлага хангасан төслийг ЖДҮХСан болон аймгийн ХХААГазар тус хариуцан, дараагийн төслийн шатны шалгаруулалтанд автоматаар шилжүүлэн тухай бүрт нь олон нийтэд мэдээлэх юм. [ЗГМ]

СТАТИСТИК

Гадаад худалдаа \$5.6 тэрбумд хүрлээ

Б.Бямбасүрэн
Шинжээч

2019 оны эхний таван сард гадаад худалдааны бараа эргэлт өмнөх оноос 10.2 хувиар өсөж, таван тэрбум 578 сая ам.доллар хүрсэн гэж Гаалийн ерөнхий газар мэдээллээ. Тайлант хугацаанд гадаад худалдааны ашиг 948.3 сая ам.доллар байгаа нь өмнөх

оноос 34.3 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Задлаад харвал экспорт өмнөх оноос 13 хувиар өсөж, гурван тэрбум 263.4 сая ам.доллар, импорт өмнөх оноос 6.3 хувиар өсөж, хоёр тэрбум 315 сая ам.долларт хүрчээ. Өнгөрсөн онд 30-40 хувиар өсөж байсан импортын өсөлт он гарснаас хойш ийнхүү саараад байна. Нийт экспортын 83.1 хувийг төмрийн хүдэр, чулуун нүүрс,

зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг эрдэс бүтээгдэхүүн эзэлжээ. Тухайлбал, чулуун нүүрсний экспортын хэмжээ өмнөх оноос 946 мянган тонноор илүү буюу 15.1 сая тонн хүрсэн байна. Чулуун нүүрснээс нэг тэрбум 271.5 сая ам.долларын орлого олсон нь нийт экспортын орлогын 39 хувийг дангаараа бүрдүүлж байгаа юм.

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Уул уурхайн хөрөнгө оруулалт 16 хувиар буурав

2019 оны эхний улиралд уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн оны гүйцэтгэлээс буурсан талаар Монголбанк мэдээлэв. Тодруулбал, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16 хувиар буурч, 443 сая ам.доллар болжээ. Улсаар нь авч үзвэл нэгдүгээр улиралд гадаадын шууд хөрөнгө оруулалтын 68 хувийг дангаараа бүрдүүлсэн Канадын хөрөнгө оруулалт буурсан байна.




Канад улсын хувьд уул уурхайн салбарын, ялангуяа “Оюу Толгой”-н хамгийн том хөрөнгө оруулагч юм.

Тус улс хөгжлийн агентлагаараа дамжуулан 1.5 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг “Оюу Толгой” төсөлд оруулсан талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар мэдээлэв. Тийм учраас “Оюу Толгой төслийг таслахгүй, хөдөлгөсөөр байх нь

Монголын ард түмэн, хөрөнгө оруулагчид аль алинд нь үр өгөөжтэй” гэж Канадын Гадаад Хэргийн туслах дэд сайд Доналд Бобиаш Монгол, Канадын дугуй ширээний уулзалтын үеэр онцлож байв.

Энэ онд “Оюу Толгой” төслийн далд уурхайн бүтээн байгуулалтад 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх төлөвтэй байгааг Сангийн яам мэдээлсэн юм.

Зах зээл



Гоо сайхны төлөөх халуурал энгийн рүү шилжинэ

Гоо сайхны үйлдвэрлэл хямралыг ажирдаггүй, тогтвортой бизнест тооцогдох болсон

◀1 Сошиал нөлөөлөгчдийн сурталчилгаанд автаж гоо сайхны бараа бүтээгдэхүүн авсан. Цаашлаад түүнийгээ тогтмол хэрэглэдэггүй хэн нэгэн та эсвэл таны эргэн тойронд байж магадгүй. Ийм төрлийн худалдан авалтын үр дүнд хэрэглэдэггүй ч хаяхад хайран бараа, бүтээгдэхүүн олширсон.

Гоо сайханд хүргэх туршилт, худалдан авалтад хэзээд бэлэн хэрэглэгчийн тоо энэ зах зээлийн багтаамж, эргэлдэх мөнгөний хэмжээг нэмэгдүүлсэн. Тиймээс үнэнч хэрэглэгчидтэй, өсөн нэмэгдэж буй энэ зах зээл бизнес эрхлэгчид, залуу энтрепренерүүдийг соронз мэт татсанаар бизнесийн өрсөлдөөн ширүүсээд байгаа юм. Гоо сайхны зах зээл олон олон тэрбумтныг төрүүлсээр байгаа. Тэднээс олон нийтэд хамгийн сайн танигдсан нь АНУ-ын телевизийн шоуны од Кайли Женнер. Нийгмийн сүлжээний хүч, орчин үеийн хэрэглэгчдийн хандлага хэмээх хүчин зүйлс 22-хон настай Кайли Женнерийг дөрөвхөн жилийн дотор дэлхийн тэрбумтнуудын эгнээнд элсүүллээ. Түүний 18 насандаа байгуулсан гоо сайхны бүтээгдэхүүний Kylie Cosmetics компанийн

зах зээлийн үнэлгээ 2019 оны эхний улирлын байдлаар 800 сая ам.долларт хүрснийг Forbes сэтгүүл мэдээлж байна. Гоо сайхны үйлдвэрлэл, бизнесийн туршлага арвин биш Кайли Женнерийн Instagram хуудас дахь дагагчдын тоо дэлхийд эхний аравт багтдаг. Түүний нийгмийн сүлжээний Instagram хуудсыг 130 сая хүн дагадаг байна. Ер нь дэлхийн гоо сайхны үйлдвэрлэл эдийн засгийн аливаа хямралыг ажирдаггүй, тогтвортой өсөлт бүхий бизнест тооцогдох болсон. Үүнд цахим худалдааны өсөлт, нийгмийн сүлжээний тэлэлт, хотжилт, дэлхийн хүн амын тоо, гоо сайхны бүтээгдэхүүний төрөлжилт зэрэг нөлөөлж, энэ зах зээлийг өсгөж байна. Мөн орчин үеийн охид бүсгүйчүүд өмнөх үеийнхэнтэй харьцуулахад илүү бага наснаасаа гоо сайхны бүтээгдэхүүн хэрэглэж эхлэх хандлага ажиглагдах болжээ. Сүүлийн арван жилд л гэхэд гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зах зээл жилд дунджаар 3-5 хувийн хурдтай тэлжээ. Ялангуяа, өнгөрсөн он энэ салбарын үйлдвэрлэгчдэд гойд өсөлттэй жил байсан бөгөөд зах зээлийн хэмжээ нь

- 5.5 хувиар өсчээ. Энэ өсөлтийг Ази, Номхон далайн бүс нутаг тэргүүлжээ.
- Ази тив дэлхийн гоо сайхны үйлдвэрлэлд сүүлийн жилүүдэд цахиур хагалж, энэ зах зээлийн 39 хувийг дангаараа бүрдүүлж байна.
- Сүүлийн арван жилд л гэхэд гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зах зээл жилд дунджаар 3-5 хувийн хурдтай тэлжээ.

- Гоо сайханд хүргэх туршилт, худалдан авалтад хэзээд бэлэн хэрэглэгчийн тоо энэ зах зээлийн багтаамж, эргэлдэх мөнгөний хэмжээг нэмэгдүүлсэн.
- Зохистой бус хэрэглээ ийнхүү хэрэглэгчдийн өрийн дарамтыг өсгөөд зосгохгүй эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж эхэлсэн учраас эмч мэргэжилтнүүд болон ашгийн бус байгууллагууд төрөл бүрийн арга хэмжээ авч байгаа аж.

Өмнө нь гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг Loreal, Unilever, Estiee Lauder зэрэг барууны компаниуд тодорхойлдог байсан бол сүүлийн жилүүдэд Япон, БНСУ, Хятад улсын үйлдвэрлэгчид хүч түрж эхэлсэн. Ялангуяа, БНСУ-д гоо сайхны үйлдвэрлэл эрчтэй хөгжиж, энэ улсыг дэлхийн гоо сайхны нийслэл хэмээн нэрлэхэд хүрээд байна. БНСУ-ын нэг хүнд ногдох гоо сайхны зардал 45 ам.доллараар хэмжигдэж байгаа нь дэлхийн дунджаас хоёр дахин өндөр үзүүлэлт. Мөн сүүлийн жилүүдэд Хятад улс гоо сайхны үйлдвэрлэлийг онилж, эрчүүдэд зориулсан бүтээгдэхүүн хөгжүүлэхэд анхаарч байна. .

Ийнхүү улс орнууд, үйлдвэрлэгчдийн өрсөлдөөн ширүүссэнээр хэрэглэгчдийн хэрэглээ, худалдан авалт нэмэгдээд байгаа юм. Барууны орнуудад зарим охид бүсгүйчүүд жилд дунджаар 2000-3000 ам.долларыг гоо сайхны бүтээгдэхүүнд зарцуулдаг аж. Гэхдээ үүнийгээ бүрэн хэрэглэлгүй хаях эсвэл хадгалахад хүрдэг. Гоо сайхан дагасан энэ халуурал, хэрээс хэтэрсэн хэрэглээ нь эргээд охид бүсгүйчүүдийн бие мах бодийг илүү эмзэг болж, янз бүрийн үрэвсэл үүсгэж эхэллээ. Үүний зэрэгцээ хэрэглэж дуусаагүй бүтээгдэхүүнүүдийн хаягдал нэмэгдэж, байгаль орчинд сөргөөр нөлөөлөхөд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, нэг талаас ашгийн төлөөх бизнесүүдийн өрсөлдөөн, сайн маркетинг менежмент, нөгөө талд гоо үзэсгэлэнтэй, гоё сайхан харагдах хүсэлтэй бүсгүйчүүдийн зогсошгүй хүсэл нь хэтийдсэн хэрэглээ дагуулж байна. Зохистой бус хэрэглээ ийнхүү хэрэглэгчдийн өрийн дарамтыг өсгөөд зосгохгүй эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж эхэлсэн учраас эмч мэргэжилтнүүд болон ашгийн бус байгууллагууд төрөл бүрийн арга хэмжээ авч байгаа аж. Тухайлбал, дэлхий даяар хэрэгцээгүй хэрэглээгээ хязгаарлах зорилготой NoBuy нэртэй хөдөлгөөн дэлгэрч, олон хүний анхаарлыг татаад байна. Уг хөдөлгөөнд Instagram хэрэглэгчид идэвхтэй нэгдэж, үрэлгэн зангаа хойш тавьж, худалдаж авсан косметик бүтээгдэхүүнээ дуустал нь хэрэглэж, илүү энгийн арьс арчилгаа руу шилжиж байна.

Тухайлбал, гоо сайхны чиглэлээр блог хөтөлдөг нэгэн бүсгүй энэ хөдөлгөөнд нэгдэж, 2018 оны турш шинэ худалдан авалт хийгээгүй аж. Тэрбээр өмнө нь сард дунджаар 220 фунтыг косметик бүтээгдэхүүнд зарцуулдаг байсан бол өдгөө 39 фунт хүртэл бууруулжээ. Чанартай бөгөөд үр дүнтэй арьс арчилгаанд олон төрлийн бүтээгдэхүүн шаардлагагүй гэдгийг мэргэжилтнүүд зөвлөж байна. Харин гоо сайхны бүтээгдэхүүнд халаасаа хоослохоос илүү эрүүл хооллолт, амьдралын зөв хэв маяг нь ямар ч бүтээгдэхүүнээр орлуулшгүй үр дүнтэй, үнэ цэнтэй хөрөнгө оруулалтад тооцогддог байна. Цаашлаад энэ нь орчин үеийн залуусыг санхүүгийн зөв зохистой хэрэглээнд сургах, өрийн дарамтаас хамгаалах, хуримтлалыг дэмжихэд ч тустай аж. Хэдийгээр харагдах байдал, халаасан дахь хэдэн төгрөгөө хэрхэн зарцуулах нь хувь хүний эрх, сонголтын асуудал. Гэхдээ зохистой бус хэтийдсэн хэрэглээ нь иргэдийн эрүүл мэнд, байгаль орчинд эрсдэл учруулж эхэлсэн тул дэлхий нийтийн чиг хандлага өөрчлөгдөж, илүү энгийн атлаа хэмнэлттэй хэрэглээ рүү шилжиж байна. [3ГМ]

DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
0.30%	0.47%	0.49%	0.33%	0.54%	0.76%	0.59%	2.58%